**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**
**/2023 оны жилийн эцсийн байдлаар/**

<table>
<tr><th rowspan="2">Бодлогын баримт бичигт тусгагдсан, болон үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт</th><th rowspan="2">Стратеги /арга зам/</th><th rowspan="2">Шалгуур үзүүлэлт</th><th rowspan="2">Суурь түвшин</th><th rowspan="2">Зорилтот түвшин</th><th rowspan="2">Санхүүгийн эх үүсвэр</th><th rowspan="2">Биелэлт</th><th colspan="2">Үнэлгээ (хувь)</th></tr>
<tr><th>Арга хэмжээ</th><th>Зорилт</th></tr>
<tr><td colspan="9">Нэг. Ерөнхий чиг үүргийн нэр: Аймгийн хүнс, хөдөө аж ахуйн салбарын хөгжлийн бодлого, төлөвлөлт</td></tr>
<tr><td colspan="9">1.1.Үндсэн чиг үүргийн нэр: Салбарын хууль тогтоомж, түүний үзэл баримтлал, бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, бодлогын удирдамжаар хангах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх, гадаад төсөл, хөтөлбөр, олон улсын байгууллагуудын арга хэмжээ хоорондын уялдааг хангаж, салбарын бодлоготой уялдуулах, салбарын чиглэлээр иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг цахимжуулах, статистик мэдээ гаргах, хэрэглэгчдийг мэдээ, мэдээллээр хангах үндсэн үүрэг хүлээж, энэ хүрээнд хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн болон жижиг, дунд үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбарын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, шинжлэх ухаан, технологи, инновац, маркетингийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөний төслийг боловсруулах, бодлогын удирдамжаар хангах, зөвлөгөө өгөх чиг үүргийг хэрэгжүүлнэ.</td></tr>
<tr><td rowspan="4">Зорилт-1. Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогыг хэрэгжилтийг хангана. /ЗГҮАХХАХТ-ийн 3.3.4/, /ЗДҮАХ-ийн 4.2./</td><td rowspan="4">Арга хэмжээ-1: Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах хөтөлбөрийг хэрэгжүүлэх</td><td rowspan="4">Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогын хэрэгжилтээр тооцно.</td><td rowspan="4">Хэрэгжилтийн дундаж хувь 85%</td><td>2021 он: Хэрэгжилтийн хувь 90%</td><td rowspan="4">Эх үүсвэр: Орон нутгийн төсөв<br>Нийт: 184.0 сая.төг<br>2021 онд: 46.0<br>2022 онд: 46.0<br>2023 онд: 46.0<br>2024 онд: 46.0</td><td rowspan="4">УИХ-ын 2015 оны 104 дүгээр тогтоолоор "төрөөс ХХАА-н Талаар баримтлах бодлог, Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн. 2017 оны 63 дугаар тогтоолоор "Төрөөс хүнс, ХАА-н талаар Баримтлах бодлогыг хэрэгжүүлэх аймгийн дэд хөтөлбөр батлагдаж, Хэрэгжилтийг хангаж ажилласан. Төрөөс ХХАА-н талаар баримтлах бодлогыг</td><td rowspan="4">91.3</td><td rowspan="4"></td></tr>
<tr><td>2022 онд: Хэрэгжилтийн хувь 95%</td></tr>
<tr><td>2023 онд: Хэрэгжилтийн хувь 100%</td></tr>
<tr><td>2024 онд: Хэрэгжилтийн хувь 100 %</td></tr>
</table>

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хэрэгжүүлэх аймгийн дэд хөтөлбөрийн 2017-2021 Оны төлөвлөгөөнд тусгагдсан МАА-н салбарын 15 арга хэмжээний хэрэгжилт 91.5%, мал эмнэлгийн салбарын 11 арга хэмжээний хэрэгжилт 92.7%, газар тариалангийн 19 арга Хэмжээний хэрэгжилт 94,7%, Хүнсний аюулгүй байдлын 14 арга хэмжээний хэрэгжилт 87,8%. Хяналт шинжилгээ үнэлгээний 3 арга хэмжээний хэрэгжилт 90%. Буюу нийт хэрэгжилтийн дундаж 91,3% байна. Тус төрөөс ХХАА-н талаар баримтлах бодлого нь УИХ-ын 2021 оны 89 дүгээр тогтоолоор хүчингүй болсон | | |
| **Хоёр. Ерөнхий чиг үүргийн нэр: Мал аж ахуйн салбарын чиглэлээр** | | | | | | | | |
| **2.1.Үндсэн чиг үүргийн нэр:** Мал аж ахуйн үйлдвэрлэл, малын генетик нөөцийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах үндсэн үүрэг хүлээж, энэ хүрээнд мал аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх, эрчимжүүлэх, бэлчээрийг зохистой ашиглах, хамгаалах, усан хангамжийг сайжруулах, малыг байгаль, цаг агаарын эрсдэлээс хамгаалах, тэжээлийн хангамжийг нэмэгдүүлэх, малчны орлого нэмэгдүүлэх, малын генетик нөөцийн үйл ажиллагааг төлөвлөх, малын үржил, селекц, генетик нөөцтэй холбоотой бодлого, стратегийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, малын генетик нөөцийн үндэсний бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, мэдээллийг тухай бүрд баяжуулах, хэрэглэгчийг мэдээллээр хангах чиг үүргийг хэрэгжүүлнэ. | | | | | | | | |
| Зорилт-1. Малын | Арга хэмжээ-1: | Чадавхижуулах | - | 2021 он: -<br>2022 онд: | Эх үүсвэр: Орон | 2021 онд ХХААХҮЯ-ны харьяа Малын удмын | 100 | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| чанар, ашиг шимийг сайжруулж, малын тоог чанарт шилжүүлж малын генийн санг хамгаалах, биотехнологийн ололтыг нэвтрүүлэх, эрчимжсэн мал аж ахуйн салбарын хөгжлийг дэмжинэ. /ЗГҮАХХАХТ-ийн 3.3.4/, /ЗДҮАХ-ийн 7.3.3/ | Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдийг чадавхжуулах сургалтад хамруулах, туршлага судлах арга хэмжээг зохион байгуулах | сургалтад хамрагдсан эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдийн тоо | | 2-оос доошгүй сургалтад хамруулсан байна.<br>2023 онд: 2-оос доошгүй сургалтад хамруулсан байна.<br>2024 онд: 2-оос доошгүй сургалтад хамруулсан байна. | нутгийн төсөв Нийт: 30.0 сая.төг 2021 онд: - 2022 онд: 10.0 2023 онд: 10.0 2024 онд: 10.0 | сангийн үндэсний төвөөс нутаг Академи ТББ-тай хамтран Бод малын зохиомол хээлтүүлгийн технологич бэлтгэх вакум сургалт 2021 оны 6 дугаар сарын 14-нөөс 27-ны хооронд Булган аймгийн Хутаг-өндөр суманд зохион байгуулагдаж Орхон аймгийн Жаргалант сумын нэг иргэн хамрагдаж үнээнд зохиомол хээлтүүлэг хийх дадлага туршлага эзэмшсэн. 2022 онд бог малын зохиомол хээлтүүлгийн технологич бэлтгэх вакум сургалтыг 2022 оны 10 дугаар сард зохион байгуулсан. Тус сургалтад Орхон аймгийн Жаргалант сумын нэг иргэн хамрагдаж хонь ямаанд зохиомол хээлтүүлэг Хийх дадлага туршлага эзэмшсэн.<br>Засгийн газрын 2020 оны 130 дугаар тогтоол Сүү боловсруулах үйлдвэр цехэд техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн түүхий сүү нийлүүлсэн | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | малчин, эрчимжсэн мал аж ахуй эхрлэгчдэд мөнгөн урамшуулал олгох журам-ын хүрээнд малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч нь үйлдвэр, цехэд малын түүхий сүү нийлүүлэх Цахим бүртгэлийн талаархи сургалтыг 2022 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр аймгийн МЭГ, Татварын хэлтэстэй хамтран зохион байгуулан ажилласан. Үүнд: 11 фермер эрхлэгч, 5 мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүд хамрагдсан.<br>Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, аймгийн Засаг даргатай 2023 онд хамтран ажиллах гэрээнд тусгагдсан бод, бог малын зохиомол хээлтүүлгийн техникч бэлтгэх сургалтад Баян-Өндөр, Жаргалант сумдын 4 иргэн хамрагдсан.<br>Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Монголын мал зүйч, үржүүлэгчдийн холбоо, Сэлэнгэ аймгийн Хүнс, | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хөдөө аж ахуйн газартай хамтран Сэлэнгэ аймгийн Сүхбаатар суманд зохион байгуулагдсан “Махны чиглэлийн үхрийн аж ахуй эрхлэгчдийн зөвлөгөөн”-д махны чиглэлийн үхрийн аж ахуй эрхэлдэг, эрхлэх сонирхолтой 9 иргэн, аж ахуйн нэгж, Төв аймгийн Зуунмод суманд зохион байгуулагдсан "ТӨВ ТҮМНИЙ СҮҮН СОЁЛ - 2023" арга хэмжээнд сүүний чиглэлийн үхрийн аж ахуй эрхлэдэг 5 иргэн, Мах-ноосны чиглэлийн Суффолк үүлдрийн хонины аж ахуйтай танилцахад 9 иргэн, нийт 23 иргэн, аж ахуйн нэгжийг тус тус хамруулан мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч туршлага судлуулан хамтран ажиллалаа.<br>“Хөгжлийн шийдэл” ТББ-тай хамтран “Хүнсний-хангамж, аюулгүй байдлыг хангах” ажлын хүрээнд “Сүүний технологи, эрүүл ахуйн зохистой дадал” сэдэвт сургалтыг зохион | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгуулж эрчимжсэн мал аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 15 иргэн, аж ахуйн нэгжийг оролцуулсан. | | |
| | Арга хэмжээ-2: Эрчимжсэн мал аж ахуйг эрхлэх ажлыг өргөжүүлэн, фермерүүдийг дэмжих | Дэмжлэгийн тоо /мөнгөн дүн/ | Үхрийн фермер 15, гахай фермер 1, тахианы аж ахуй 5, зөгийн 14 аж ахуйн нэгж | 2021 он: -<br>2022 онд: Төсөл хөтөлбөрт хамруулан дэмжсэн байна.<br>2023 онд: Төсөл хөтөлбөрт хамруулан дэмжсэн байна.<br>2024 онд: Төсөл хөтөлбөрт хамруулан дэмжсэн байна. | Эх үүсвэр: Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр Нийт: 1.800,0 сая.төг 2021 онд: - 2022 онд: 600.0 2023 онд: 600.0 2024 онд: 600.0 | 2021 онд: аймгийн хэмжээнд 108 иргэн эрчимжсэн МАА эрхэлж байна. Үүнд сүүний чиглэлийн 20 иргэн, 494 толгойн үхэр, гахайн аж ахуй эрхэлж 2 иргэнд 88 толгой гахай шувууны аж ахуйн чиглэлээр 7 иргэн 1253 толгой шувуу, 14 иргэн 274 бол зөгийн өсгөн үржүүлж үйл ажиллагаагаа явуулж байна. Монгол Улсын ЗГ-ын хэрэгжүүлж буй "ажлын байрыг дэмжих" хөтөлбөрөөс эрчимжсэн МАА-н чиглэлээр үйл ажиллагаагаа Хүн явуулдаг "Оникс-Агат" ХХК 150 сая төгрөгийн зээлийг 43,7%-ийн зээлийн батлан даалтыг дэмжлэг авсан. Жаргалант сумын сум хөгжүүлэх сангаас үхэр сүргийн чанарыг сайжруулах ашиг шимийг нэмэгдүүлэх зорилгоор 3 иргэд 23 сая | 100 | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төгрөг мах ноосны чиглэлийн "Суффолк" үүлдрийн хонь өсгөн үржүүлэх ашиг шимийг нэмэгдүүлэх угсааг үүлдэр сайжруулах зорилгоор 1 иргэд 6 сая төгрөг нийт 4 иргэн 29 сая төгрөгийн зээл хөнгөлөлттэй олгосон. 2022 онд: аймгийн хэмжээнд 132 иргэн эрчимжсэн МАА эрхэлж байна. Үүнд: 19 иргэн сүүний чиглэлийн 294 толгой үхэр, 7 иргэн, махны чиглэлийн 354 толгой үхэр 1 иргэн 85 толгойн махны чиглэлийн нарийн ноост хонь 9 Иргэн 252 Толгой гахай 81 иргэн 1298 Толгой шувуу, 4 иргэн 229 бүл зөгий 1 иргэн 7 толгой туулай тус тус өсгөн үржүүлж байна. Баян-өндөр сумын хоршоог хөгжүүлэх сангийн зээлд "чамин үзэг" ХХК нь зөгийн аж ахуйн үржүүлгийг сайжруулах, ашиг шим болон бүл нэмэгдүүлэх зорилгоор 35 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамрагдсан. "Ижил | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | марал" ХХК нь жижиг, Хүн дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 94,2 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамрагдан Хүн сүүний чиглэлийн үхрийн фермерийн өргөжүүлэн үйл ажиллагаа явуулж иргэдийг эрүүл ахуйн шаардлага хангасан сүү сүүн бүтээгдэхүүнээр ханган ажиллаж байна. 2023 оны эхэнд аймгийн хэмжээнд 168 иргэн эрчимжсэн мал аж ахуй эрхэлж өмнөх оноос 27.0 хувиар өссөн байна. Үүнд: 30 иргэн мах, сүүний чиглэлийн 370 толгой үхэр, 11 иргэн махны чиглэлийн 414 толгой үхэр, 2 иргэн 269 толгой махны чиглэлийн нарийн ноост хонь, 12 иргэн 590 толгой гахай, 78 иргэн 3195 толгой шувуу, 15 иргэн 329 бүл зөгий, 4 иргэн 96 толгой туулайг тус тус өсгөн үржүүлж байна. Жаргалант сумын “Хоршоо хөгжүүлэх сан”-гаас 3 иргэнд 73.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгосон. Тус | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | иргэд нь мах, сүүний чиглэлийн үхэр сүргийн чанарыг сайжруулж, үйл ажиллагаагаа өргөжүүлэн ажиллаж байна.<br>Баян-Өндөр сумын “Хоршоо хөгжүүлэх сан”-аас Эрчимжсэн аж ахуйн чиглэлээр 3 иргэнд 65.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон.<br>Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч фермерүүдийг дэмжих ажлын хүрээнд “Эрдэнэт хот орчмын сүүний үхрийн фермерүүдийн холбоо”-нд ногоон тэжээл боох төхөөрөмж худалдан авахад 15.0 сая/төгрөгний дэмжлэг үзүүлсэн.<br>Засгийн газрын 2023 оны 63 дугаар тогтоолоор хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих ажлын хүрээнд эрчимжсэн мал аж ахуйн эрхлэж байгаа 3 аж ахуйн нэгж, 1 иргэн 3.082.220.0 төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамрагдсан. | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Арга хэмжээ-3: Аймгийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг бүрдүүлэх | Аюулгүйн нөөцийг 100% бэлтгэнэ. | өвс 190 тн, тэжээл 70 тн | 2021 он: Аюулгүйн нөөцийг 100% бэлтгэнэ.<br>2022 онд: Аюулгүйн нөөцийг 100% бэлтгэнэ.<br>2023 онд: Аюулгүйн нөөцийг 100% бэлтгэнэ.<br>2024 онд: Аюулгүйн нөөцийг 100% бэлтгэнэ. | Эх үүсвэр: Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр Нийт: 220.0 сая.төг 2021 онд: 40.0 2022 онд: 60.0 2023 онд: 60.0 2024 онд: 60.0 | 2021 онд: Монгол Улсын Засгийн газрын 2021 о оны 221 дүгээр тогтоолоор аймаг, сумдын өвс, тэжээлийн аюулгүй нөөцөд 160 тонн өвс 50 тонн тэжээл бэлтгэхээр төлөвлөгдсөнөөс нийт 275 Тонн өвс 53,9 тонн тэжээлийг бэлтгэсэн. Үүнд аймгийн аюулгүйн нөөцөд 100 тонн өвс 40 тонн тэжээл Баян-өндөр сумын нөөцөд 100 тонн өвс 13.9 тонн багсармал тэжээл Жаргалант сумын нөөц 75 тонн өвс тус тус бэлтгэсэн. 2022 онд аймгийн ХАА-н салбарын 2022-2023 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын төлөвлөгөөг аймгийн ИТХ-ын 2022 оны ээлжит IX хуралдааны 09/02 дугаар тогтоолоор батлуулан ажилласан.Аймаг сумдын өвс тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлэхэд орон нутгийн төсвөөс 164,7 сая төгрөгийг шийдвэрлүүлэн аймгийн аюулгүйн нөөцөд 100 | 100 | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тонн өвс 37,5 тонн тэжээл, сумдын аюулгүй нөөцөд 118 тонн өвс, 35,9 тонн тэжээл, нийт 218 тонн өвс 73,4 тонн тэжээлийг бэлтгэсэн.<br>Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 279 дүгээр тогтоолын дагуу аймаг, сумдын аюулгүйн нөөцөд нийт 200 тн өвс, 86.1 тн тэжээлийг 175.0 сая төгрөгөөр бэлтгэхээр төлөвлөсөн.<br>аймгийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөцөд 50 тн өвс, 51.1 тн тэжээл, Жаргалант сумын өвс, тэжээлийн аюулгүйн нөөцөд 70 тн өвс, 10 тн тэжээл, Баян-Өндөр сумaнд өвс, тэжээлийн аюулгүйн нөөцөд 80 тн өвс, 25 тн тэжээл, нийт 200 тн өвс, 86.1 тн тэжээлийг 100 хувь бэлтгэсэн. | | |
| Зорилт-2. Бэлчээрийг усжуулах, худагжуулах ажлыг үргэлжлүүлэн малын бэлчээрийн усан | Арга хэмжээ-1: Худаг уст цэгийг шинээр гаргах болон сэргээн засварлаж | Шинээр гаргасан, сэргээн засварласан худгийн тоо | Бэлчээрт 71 худаг ашиглагдаж, малчин өрхийн 80% усаар хангагдсан. | 2021 он: -<br>2022 онд: 2 худаг шинээр, 2 худаг сэргээн засварлана.<br>2023 онд: 2 худаг | Эх үүсвэр: Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр Нийт: 270.0 сая.төг | 2021 онд: бэлчээрийн усан хангамжийг сайжруулах зорилгоор Жаргалант сумын Орон нутгийг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр Дулаан-Уул багийн хөвөр шувууд зэрэг газруудад шинээр 2 | 100 | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| хангамжийн хүрэлцээг тогтвортой байлгана. /ЗГҮАХХАХТ-ийн 3.3.4/, /ЗДҮАХ-ийн 7.3.4./ | малчдад эзэмшүүлэх | | | шинээр, 2 худаг сэргээн засварлана.<br><br>2024 онд: 2 худаг шинээр, 2 худаг сэргээн засварлана. | 2021 онд: -<br>2022 онд: 90.0<br>2023 онд: 90.0<br>2024 онд: 90.0 | худаг гаргасан. Мөн хавчиг наранд 2 худаг насос шинээр тавьж сэргээн засварласан. Үүний үр дүнд 43 өрхийн энэ 8,3 мянган толгой мал усаар хангагдах боломж бүрдэж байна. 2022 онд: 2 худаг шинээр 2 худаг сэргээн засварлан завсарласан. Бэлчээрийн усан хангамжийг сайжруулах зорилгоор Жаргалант сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Дулаан-Уул Хүн багийн Хөөвөр шувууд зэрэг газруудад шинээр худаг гаргасан. Үүний үр дүн 43 өрхийн 8.3 мянган толгой мал усаар хангагдах боломж бүрдсэн.<br>Энэ онд улсын төсвийн хөрөнгөөр Жаргалантын ам, Хөндлөн намагт 2 худаг, Жаргалант сумын орон нутгийн хөгжлийн сангаас Аргуу, Хөшөөт, Согоотод 3 худаг нийт 5 худгийг 290.9 сая төгрөгөөр шинээр гаргаж, 2 худаг сэргээн засварласнаар 63 өрхийн 17.8 мянган | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | толгой мал усаар хангагдсан. | | |
| | Арга хэмжээ-2: Бэлчээрт үлийн цагаан оготны тандалт судалгаа хийх | Тандалт судалгаа хийгдсэн байна. | Бэлчээрийн тандалт, судалгааг бэлчээрийн 30%-д хийсэн. | 2021 он: - | Эх үүсвэр: Орон нутгийн төсөв Нийт: 6.0сая.төг 2021 онд: - 2022 онд: 2.0 2023 онд: 2.0 2024 онд: 2.0 | 2021 онд: ХХААГ Ус цаг уур, орчны шинжилгээний төвтэй хамтран Жаргалант сумын бэлчээрийн талбайд "Хөнөөлт мэрэгчид тархсан голомт нутгийн байршлыг тодорхойлох"Хүн судалгааг 2021 оны 5, 10 дугаар саруудад хийж гүйцэтгэсэн. Судалгааг Жаргалант сумын Дулаан-уул багийн согоот, Айргийн гозгор, Баруун булаг, Зүүн булаг зэрэг бэлчээр 10 мянган га талбайд хийсэн. Зүүн булгийн бэлчээрийн талбайд мэрэгчдийн нүх үлий илчээр илэрч голомтод шар чичүүл монгол чичүүл тархсан байна. Бэлчээрийн үлийн цагаан оготны тархалт ажиглагдаагүй. 2022 онд Жаргалант сумын Дулаануул багийн 4000 га бэлчээрийн талбайгаар 2022 оны 6 дугаар сарын 20-ноос 23-ны өдрүүдэд үлийн цагаан оготно болон бусдын мэрэгчдийн | 100 | |
| | | | | 2022 онд: Бэлчээрийн тандалт, судалгааг бэлчээрийн 10%-д хийсэн байна. | | | | |
| | | | | 2023 онд: Бэлчээрийн тандалт, судалгааг бэлчээрийн 10%-д хийсэн байна. | | | | |
| | | | | 2024 онд: Бэлчээрийн тандалт, судалгааг бэлчээрийн 10%-д хийсэн байна. | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бэлчээр дэх голомт нутгийн байрлал тархалтын хүрээ, тэдгээрийн нэг талбай дахь тоо толгой, үнэмлэхүй нягтшил, бэлчээрийн ургамалд учруулах хор хөнөөлийн хэмжээг тодорхойлох судалгаа хийсэн. Судалгааг Дулаануул багийн Согоот 18-ын карьер хөөвөр, Баруун булаг, Зүүн булаг, Хөндлөн намаг,Тугалч,Панзын далиу, зэрэглээ, Хүүхдийн овоо, Арцатын өвөр зэрэг газруудаар явж ХААЦУ-ын бэлчээрийн ургамлын ажиглалтын. ШЗ.Х.03-05-2011 зааврын дагуу мэргэчид тархсан голомт нутаг тархалтын хүрээг тодорхойлох, зуучлахыг байдалд үнэлгээ өгөх ажлуудыг хийж гүйцэтгэв. Судалгаа хийсэн газруудад иргэд малчид, тариаланчдаас мэдээлэл авах мэргэчид амьдарч болох газруудад очих ажиглалт хийхэд мэрэгч амьтдын тархалт илрээгүй болно. | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Ойрхон аймгийн нутаг дэвсгэрт үлийн цагаан оготнын тархац байхгүй болно. га бэлчээрийн талбайтай. Энэ жил үлийн цагаан оготны тандалт судалгааг 4000 га газарт хийж гүйцэтгэсэн.<br>Өвөл хаврын бэлчээрийн даац нутгийн 30 хувьд мал өвөлжилт, хаваржилт хэвийн байхаар харин 70 хувьд бэлчээрийн даац 3-5 дахин хэтэрсэн байна. | | |
| Зорилт-3. Орон нутгийн онцлогт зохицсон ашиг шимийн чиглэлийн үүлдэр, омгийн цөм сүргийн малаар сайжруулна. /ЗГҮАХХАХТ-ийн 3.3.4/, /ЗДҮАХ-ийн 7.3.5/ | Арга хэмжээ-1: Бог малын хээлтүүлэгчийг мэргэжлийн ажил үйлчилгээний нэгжид ялган төвлөрүүлэх | Ялган төвлөрүүлсэн бог малын хээлтүүлэгчийн эзлэх хувь | 496 толгой хуц, ухна тоологдсоноос 81% буюу 402 толгой хуц, ухныг 3 суурьт ялган төвлөрүүлсэн. | 2021 он: -<br>2022 онд: Бог малын хээлтүүлэгчийн 80-аас дээш хувийг ялган төвлөрүүлнэ.<br>2023 онд: Бог малын хээлтүүлэгчийн 80-аас дээш хувийг ялган төвлөрүүлнэ.<br>2024 онд: Бог малын хээлтүүлэгч | Эх үүсвэр: Орон нутгийн төсөв Нийт: 150.0 сая.төг 2021 онд: - 2022 онд: 50.0 2023 онд: 50.0 2024 онд: 50.0 | 2021 онд Баянөндөр сум 120 толгой, хуц, ухна. Жаргалант сум 434 толгой хуц ухныг ялгаж нийт хуц ухны 81,8%-ийг ялган төвлөрүүлж, үзлэг ангилалт хянан баталгаажуулалт, мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд бүрэн хамруулан ажилласан.Мөн аймаг аймгийн хэмжээнд 100 677 хуудас ухна тоологдсоноос 554 толгой, хуц, ухныг 2 сумын 4 суурьт суурилж мэргэжлийн ажил үйлчилгээний нэгжийн хяналтаа авч малыг бүр | 100 | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | ийн 80-аас дээш хувийг ялган төвлөрүүлнэ. | | хэвлэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн. Бог малын чанарыг сайжруулах зорилгоор Жаргалант сумын орон тоо нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Баяд үүлдрийн 50хуц Эрчим хар үүлдрийн 25 ухна, нийт 75 хуц ухныг шинээр нөхөн тавьсан. | | |
| | Арга хэмжээ-2: Мал сүрэгт үзлэг ангилалт, ялган тэмдэглэгээ хийх, бүртгэлжүүлэх ажлыг эрчимжүүлэх, бүртгэл мэдээллийн нэгдсэн санд хамруулах | Үзлэг ангилалт, хянан баталгаажуулалт хийсэн малын тоо | 35.8 мянган толгой малд үзлэг ангилалт, хянан баталгаажуулалт хийсэн. | 2021 он: Нийт богийн хээлтүүлэгчийг 100, богийн хээлтэгчийн 60 хүртлэх хувийг хамруулна.<br>2022 онд: Нийт богийн хээлтүүлэгчийг 100, богийн хээлтэгчийн 60 хүртлэх хувийг хамруулна.<br>2023 онд: Нийт богийн хээлтүүлэгчийг 100, богийн хээлтэгчийн | Эх үүсвэр: Орон нутгийн төсөв Нийт: 24.0 сая.төг 2021 онд: 6.0 2022 онд: 6.0 2023 онд: 6.0 2024 онд: 6.0 | 2021 онд Баянөндөр сум 120 толгой хуц ухна Жаргалант сум 434 толгой хуц ухныг ялгаж нийт хуц ухнын 81,8%-ийг ялган төвлөрүүлж үзлэг ангилалт, хянан баталгаажуулалт мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд бүрэн хамруулан ажилласан.<br>2022 онд 37 мянга толгой малыг үзлэг ангилалд хянан баталгаажуулалтад хамруулж ,7025 Толгой буюу 19% цөм сүрэг, 26845 толгой буюу 72,5% үржлийн сүрэг , 3130 толгой буюу 8,5% нь хэрэгцээний сүрэгт бүртгэгдэж, анги, | 100 | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 60 хүртлэх хувийг хамруулна. | | чанарыг тодорхойлон ажилласан.<br>Мөн 2.0 мянган толгой малыг ялган тэмдэглэхээр төлөвлөснөөс Орон нутгийн төсвөөр 2.0 мянган толгой мал Жаргалант сумын орон нутгийн хөгжлийн сангийн төсвөөр 3,6 мянган толгой мал нийт 5,6 мянган толгой малыг ялган тэмдэглэж малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн.<br>2023 оны эхэнд хуц-456 ухна-392 нийт-848 толгой хуц, ухна тоологдсоноос 724 толгой хуц, ухна буюу 85.4 хувийг 4 суурьт ялган суурилж, мэргэжлийн ажил үйлчилгээний нэгжийн хяналтад авч үзлэг ангилалт, хянан баталгаажуулалт, ялган тэмдэглэгээ хийж, мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд бүрэн хамруулан ажиллаж, малын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн. | | |
| | | | | 2024 онд: Нийт богийн хээлтүүлэгчийг 100, богийн хээлтэгчийн 60 хүртлэх хувийг хамруулна. | | | | |

<table>
<tr><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td>2022 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар худалдан авсан 60 хуц, 40 ухна нийт 100 өсвөр хээлтүүлэгчийг шинээр нөхөн тавьсан.</td><td></td><td></td></tr>
<tr><td colspan="9">Гурав. Ерөнхий чиг үүргийн нэр: Газар тариалангийн салбарын чиглэлээр</td></tr>
<tr><td colspan="9">3.1.Үндсэн чиг үүргийн нэр: Газар тариалангийн үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах үндсэн үүрэг хүлээж, энэ хүрээнд тариалангийн үйлдвэрлэлийн байгаль, цаг агаарын эрсдэл даах чадавхыг нэмэгдүүлж уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, үр, сортын шинэчлэл, хөрсний үржил шимийг сайжруулах, хамгаалах, таримал ургамлын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн тогтвортой, хүртээмжтэй хангамжийг бий болгох тариалангийн үйлдвэрлэлд байгаль орчинд ээлтэй техник, технологи нэвтрүүлэн тогтвортой хөгжлийг хангах, эрчимжүүлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.</td></tr>
<tr><td rowspan="3">Зорилт-1. Тариалангийн нийт эргэлтийн талбайн ашиглалтыг сайжруулж, газар тариалангийн хүрсэн түвшинг тогтворжуулан хөгжүүлнэ. /ЗГҮАХХАХТ-ийн 3.3.1/, /ЗДҮАХ-ийн 7.3.1./</td><td rowspan="3">Арга хэмжээ-1: Төмс, хүнсний ногооны техник шинэчлэлийг үргэлжлүүлэн, ашиглалтыг сайжруулан, агропарк байгуулах</td><td rowspan="3">Агропарк байгуулагдаж, техник, тоног төхөөрөмжийн техник шинэчлэл хийгдсэн байна.</td><td rowspan="3">Агро үйлчилгээний төвд 41.8 сая төгрөгийг шийдвэрлэн LOVOL-824 трактор худалдан авсан.</td><td>2021 он: Агропарк байгуулах төсөл боловсруулан, санхүүжилт татсан байна.</td><td rowspan="3">Эх үүсвэр: Орон нутгийн төсөв Нийт: 240.0 сая.төг 2021 онд: 120.0 2022 онд: 120.0 2023 онд: - 2024 онд: -</td><td rowspan="3">2021 онд Жаргалант сумын Засаг даргын захирамжаар Агро парк байгуулах 2,4 га газрын асуудлыг шийдвэрлэсэн. Жаргалант суманд агро паркийг байгуулан тус газрыг 481 метр хашаагаар хашаажуулан Гүний худаг барих ажлыг гүйцэтгэсэн. Каритас Монгол ТББ-ын хэрэгжүүлж буй Хүнсний аюулгүй байдал ба газар тариаланг дэмжих хөтөлбөрт Санал хүргүүлснээр аймгийн ХХААГ Жаргалант сумын ЗДТГ Каритас Монголд ТББ хамтран ажиллах санамж бичгийг байгуулан Нарны эрчим</td><td rowspan="3">98</td><td rowspan="3"></td></tr>
<tr><td>2022 онд: Техник, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийгдсэн байна.</td></tr>
<tr><td>2023 онд: Агропаркийн үйл ажиллагаа хэвийн явагдана.</td></tr>
</table>

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 2024 онд: Агропаркийн үйл ажиллагаа хэвийн явагдана. | | хүчээр ажиллах 3 улирлын 480м2 хүлэмжийг агро паркийн талбайд барьсан. Агро паркийн хашаа худаг барих ажилд орон нутгийн төсвөөс хашаа худаг барихад 120 .0 сая Хүлэмж барих ажилд Каритас Монгол ТББ-аас 40 сая төгрөг зарцуулсан. 2022 онд төмс хүнсний ногооны үйлдвэрлэл эрхлэгч 68 иргэний 67.3 га Талбайд хагалгаа тариалалт хийж 24 иргэний 13 га талбайд төмс хураах 19 иргэний 54 га талбайн хадлан хадах 23 иргэний 62,13 га талбайн тэжээлийн таримлыг тармаж, 13 Иргэний өвс тэжээлийг хаман боох чиглэлийн ажлыг техник дундын төв хийж гүйцэтгэсэн бөгөөд Нийт 147 иргэний 196,5 га талбайд 5 төрлийн үйлчилгээ үзүүлэн дэмжин ажилласан. Газар тариалангийн үйлдвэрлэлийг технологийн хугацаанд чанартай гүйцэтгэх, шуурхай зохион байгуулах ажлын хэсгийг | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | аймгийн Засаг даргын 2023 оны А/429, А/657 дугээр захирамжаар батлуулан хэрэгжилтийг хангаан ажилласан. 2023 онд аймгийн хэмжээнд 12 аж ахуйн нэгж, 563 өрх үр тариа 3904 га, малын тэжээл 287 га, тосны ургамал 821 га, төмс 145 га, хүнсний ногоо 455 га, нийт 5612 га талбай тариалалт хийж 3600 га талбайд уриншийн боловсруулалтыг хийж гүйцэтгэсэн. Орхон аймгийн хөдөө аж ахуйн салбарын 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах ажлын төлөвлөгөөнд газар тариалангийн салбарын 14 арга хэмжээг тусган хэрэгжилтийг хангаан ажилласан. Үүний үр дүнд 5612 га талбайд хийж хураалтын ажил 100 хувь хийж гүйцэтгэсэн. Үр тариа 3904 га талбайгаас 10892 тн буюу га-аас 28 цн ургац үүнээс улаан буудай 3805 га талбайгаас 10752 тн буюу 28 цн ургац, төмс | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 145 га талбайгаас 1628 тн буюу га-аас 112 цн ургац, хүнсний ногоо 455.2 га талбайгаас 9520 тн буюу га-аас 209 цн, тэжээлийн ургамал 287 га талбайгаас 1122 тн буюу га-аас 39 цн, тосны ургамал 821 га талбайгаас 300 тн буюу га-аас 3.7 цн ургац тус тус хураан авсан. Ургацын мэдээгээр тооцоход аймгийн хүн амын хэрэгцээт үр тариа 100 хувь, төмс 43.3 хувь, хүнсний ногоо 100 хувь орон нутгийн үйлдвэрлэлээр хангаж байна.<br>Улаан буудай борлуулалт: Гурилын үйлдвэр, Хөдөө аж ахуйн корпораци ТӨХХК-д хүнсний буудай 8100 тонн, Улсын үрийн нөөц, Хөдөө аж ахуйн корпораци ТӨХХК-д үрийн буудай 804 тонн, өөрийн үрийн нөөцөд 1042 тонн, малын тэжээлд 465 тонн тус тус нийлүүлсэн. | | |
| | Арга хэмжээ-2: Төмс, | Хашаажуулалт хийгдсэн | Жаргалант суманд төмс, хүнсний | 2021 онд: -<br>2022 онд: Төмс, | Эх үүсвэр: Улсын төсөв | Хөрсний элэгдэл эвдрэлийг бууруулах үржил шимийг | 100 | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хүнсний ногооны талбайг хашаажуулах ажлыг зохион байгуулах | талбайн хэмжээ | ногооны 250 га талбайг хашаажуулсан. | хүнсний ногооны 20 га талбайг хашаажуулна.<br>2023 онд: Төмс, хүнсний ногооны 20 га талбайг хашаажуулна.<br>2024 онд: Төмс, хүнсний ногооны 20 га талбайг хашаажуулна. | Нийт: 84.0 сая.төг<br>2021 онд: -<br>2022 онд: 28.0<br>2023 онд: 28.0<br>2024 онд: 28.0 | нэмэгдүүлэх зорилгоор үр тарианы үйлдвэрлэл эрхлэгч ААН-үүд Степняк- 4.2; 5.6; Хөрс сийрүүлэгч торнадо нэмэлт төхөөрөмжөөр үр тарианы комбэйн бүрийг тоноглож сүрлийг хэрчиж цацах технологийг ашиглан , жил бүр талбайг хашиж малын хөлөөс хамгаалж байна. Мөн мөн тариалангийн газрын хөрсний үржил шим сайжруулах ажлын хүрээнд нийлмэл бордоо болон органик бордоог /гумил люкс/ Үндсэн болон нэмэлт бордоог хэрэглэж хэвшсэн. Аймгийн хэмжээнд нийт 177км хашаагаар 3615 Га Тариалангийн талбайг хашиж хамгаалсан. Үүнд 193 иргэний эзэмшлийн 257 га талбайг хашиж хамгаалсан байна. Бүтэн сайн хэр болчихсон юм. Жаргалант сумын Бөөн бургас-д 10,2 км, Мухар буланд 15км ногооны хашааг улсын төсвийн хөрөнгөөр барьж ашиглалтад оруулж , Тус сумын ЗДТГ-ын өмчид | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шилжүүлэн өгч бүртгэлд хамруулсан. Төмс, хүнсний ногооны талбайг хашаажуулах дэмжлэг: Орон нутгийн төсвийн 250.0 сая төгрөгийн хөрөнгөөр хашаажуулах ажлыг төлөвлөж Жаргалант сумын Бөөн бургастад 3.6 км хашаа шинээр барьж, 36-р точикт 1.5 км хашаа сэргээн засварласан. Үүний үр дүнд төмс, хүнсний ногооны тариалан эрхлэгч 49 иргэний эзэмшлийн 51 га талбайг хашиж хамгаалсан. | | |
| Зорилт-2. Усалгаатай тариаланги йн талбайг нэмэгдүүлж үр тариа, тэжээл, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний тариаланги йн талбай, нэгжээс авах ургацын хэмжээг | Арга хэмжээ-1: Усалгааны тоног төхөөрөмжи йг хөнгөлөлттэ й зээлээр худалдан авахад иргэн, аж ахуйн нэгжийг дэмжин ажиллах | Дэмжлэгт хамрагдсан аж ахуй нэгжийн тоо, талбайн хэмжээ | 1 аж ахуйн нэгж 50 га талбайн инженерийн хийцтэй услалтын системийн дэмжлэгт хамрагдсан. | 2021 онд: Аж ахуйн нэгжийг услалтын системийн дэмжлэгт хамруулна.<br>2022 онд: -<br>2023 онд: Аж ахуйн нэгжийг услалтын системийн дэмжлэгт хамруулна.<br>2024 онд: - | Эх үүсвэр: Улсын төсөв болон төсөл хөтөлбөр Нийт: 600.0 сая төг 2021 онд: 300.0 2022 онд: - 2023 онд: 300.0 2024 онд: - | 2021 онд аймгийн хэмжээнд төмс хүнсний ногоог гадаргуугийн усалгааг шуудуу болон бага оврын усалгааны тоног төхөөрөмж/намираа/ ашиглан тариалж байна. Жаргалант сум нь төмс хүнсний ногоог шуудуугаар услах боломжгүй талбайтай ногоочдыг дэмжин бага оврын усалгааны иж бүрдлийг 6 ширхгийг сум орон нутгийн төсвөөс 9,9 сая төгрөгийг | 100 | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| нэмэгдүүлнэ. /ЗГҮАХХАХТ-ийн 3.3.1/, /ЗДҮАХ-ийн 7.3.2./ | | | | | | зарцуулсан. Үүний үр дүнд 15 га талбайг бага оврын усалгааны тоног төхөөрөмжөөр услах боломж бүрдсэн. 2022 онд Мухар булан орчмын төмс хүнсний ногооны талбайн усалгааны шуудуу боолтыг сэргээн засварлах ажлыг тариаланчдын оролцоотой хийж гүйцэтгэж 3.0 сая Төгрөгийг орон нутгийн төсвөөс зарцуулсан. Үүний үр дүнд 72 өрхийн 90 орчим га талбайн талбайг гадаргын усалгаагаар услах боломж бүрдсэн. Энэ энэ онд инженерийн хийцтэй 10 га талбай хүнсний ногоо тариалж 135 тонн буюу га-аас 135 тонн гадаргын усалгаатай 263 га талбайд төмс тариалж 2937 тонн буюу гагаас 112,5 хүнсний ногоо 503 га талбайд тариалж 503 га талбайд тариалж 7317 тн буюу га аас 145 тн ургац тус тус хураан авсан. 2023 онд Шинэ хөдөө төслийн хүрээнд улсын төсвийн | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хөрөнгөөр 12 ширхэг 1 га услах хүчин чадалтай бороожуулах услалтын системийг хүлээн авч усалгаатай тариалангийн талбайг нэмэгдүүлэн ажиллаж байна. Энэ онд төмс 72 га, 455 га хүнсний ногоог усалгаатай нөхцөлд тариалсанбөгөөд үүнээс гадаргуугийн усалгаатай 450га буюу 85 хувь, усалгааны тоног төхөөрөмжөөр 77 га буюу 15 хувь байна. Энэ онд усалгаатай нөхцөлд төмс 77 га-аас 828 тонн буюу 1 га-аас 115 цн, хүнсний ногоо 455 га-аас 5640 он буюу 1 га-аас 124 цн ургац тус тус хураан авсан. | | |
| | Арга хэмжээ-2: Өрхийн тариалалтыг дэмжих хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх | Хөтөлбөрт хамрагдсан өрхийн тоо | Жил бүр 1000 өрхийг хөтөлбөрт хамруулсан. | 2021 онд: Хөтөлбөрийн хэрэгжилт 30%<br>2022 онд: Хөтөлбөрийн хэрэгжилт 60%<br>2023 онд: Хөтөлбөрийн хэрэгжилт 80% | Эх үүсвэр: Орон нутгийн төсөв Нийт: 560.0 сая.төг 2021 онд: 110.0 2022 онд: 150.0 | 2021 онд төмс сонгины үрийн шинэчлэл хийх зорилгоор 35 тонн төмсний үр 610кг төл сонгиныг 338 өрхөд олгож тариалалт хийлгэсэн. ХХААХҮ-ийн сайдын 2021 оны А 135 дугаар тушаалаар 80%-ийн хөнгөлөлттэй нөхцөлөөр олгох үрийн хуваарийг баталж | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 2024 онд: Хөтөлбөрийн хэрэгжилт 100% | 2023 онд: 150.0<br>2024 онд: 150.0 | Манай аймагт 85 тонн үрийн улаан буудайг 3 аж ахуйн нэгж 6 тонн түлш, сонгино, 600кг саримс, 130кг, 8 төрлийн ногооны үрийг 243 өрхөд олгосон.<br>Нийлэг хальсан хүлэмж 23 ширхгийг орон нутгийн төсвөөр худалдан авч хүлэмжийн аж ахуй эрхлэгч 23 иргэнд 50%-ийн Хөнгөлөлттэй нөхцөлөөр олгосон гэр хорооллын айл өрхүүдийг хашаандаа жимсний мод тариалах ажлын хүрээнд 1500 ширхэг үхрийн нүдний Суулгацыг 100 өрхөд хөнгөлөлттэй нөхцөлөөр олгон жимсний мод тарих арчлах талаар сургалтыг цахимаар зохион байгуулан ажилласан. Сум хөгжүүлэх сангаас 7 иргэнд 60 сая төгрөг эрүүл мэндээ хамгаалж эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөөний хүрээнд Олгож буй жилийн 3%-ийн хүүтэй зээлд төмс хүнсний ногооны үйлдвэрлэл эрхлэгч нэг | | |
| | | | | 2022 онд: Мал аж ахуйн үйлдвэрлэлд хөдөө аж ахуйн зохистой дадлыг нийт малчин өрхийн 3 хувийг хамруулан нэвтрүүлсэн байна. | | | | |
| | | | | 2023 онд: Мал аж ахуйн үйлдвэрлэлд хөдөө аж ахуйн зохистой дадлыг нийт малчин өрхийн 7 хувийг хамруулан нэвтрүүлсэн байна. | | | | |
| | | | | 2024 онд: Мал аж ахуйн үйлдвэрлэл | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | д хөдөө аж ахуйн зохистой дадлыг нийт малчин өрхийн 15 хувийг хамруулан нэвтрүүлсэн байна. | | ААН 2 иргэн 40 сая төгрөг. Нийт нэг ААН 9 иргэн 100 сая төгрөгийн зээлийн дэмжлэгт хамрагдсан.<br>Хөтөлбөрийн дэмжлэгт нэг ААН 713 иргэн хамрагдсан байна. Тус ажлыг хийж гүйцэтгэхэд орон нутгийн төсвөөс өр худалдан авахад 44,8 сая төгрөг хүлэмж худалдан авахад 58,74 Сая төгрөгийг зарцуулсан<br>2022 онд :1. Орон нутгийн төсвөөс 28,5 сая төгрөгөөр 10 тонн төмсний үр нэг тонн төл сонгино 3 мянган ширхэг өргөст хэмхийн үрсэлгээ 125,7 сая төгрөгөөр 27 ширхэг хүлэмж худалдан авсан.<br>2. ЗГ-ын 2022 оны 118 дугаар тогтоолоор хүнсний ногооны үрийн үнийг 80% хөнгөлж 11 төрлийн 410кг үр, 2 тонн түлш, сонгино, 2 тонн төмсний элит үрийг олгосон.<br>3. Жаргалант сумын агро паркийг түшиглэн төмс хүнсний ногооны 500 тонн багтаамжтай | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зоорийг барихаар Орон нутгийн төсөвт 300 сая төгрөгийг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br>4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын олон талт түншлэлийн хүрээнд үйлдвэрлэгч баг төслөөр 60 ширхэг хүлэмж нийлүүлэгдсэн.<br>5. Каритас Монгол байгууллагын дэмжлэгийн хүрээнд нарны эрчим хүчээр ажиллах 3 улирлын 480м2 хүлэмжийг Агро паркийн талбайд барьж ашиглалтад оруулан иргэд иргэдэд гэрээгээр эзэмшүүлсэн. Үүний үр дүнд давхардсан тоогоор 2 сумын 700 өрхийг ногооны үрийн, 87 иргэн , ААНБ-ыг хүлэмжийн дэмжлэгт хамруулан нарлаг хүлэмж 1140 м2-аар нийлэг хальсан Хүлэмж 9224м2-аар нэмэгдэж хүлэмжийн тариалалт 3,2 га талбайд Хүрч 278 тонн ургац хураан авсан нь хүнсний Ногооны нийт ургацад хүлэмжийн ургац нь 4,7%-ийг эзэлж | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгаа нь өмнөх оноос 0,4%-аар стандартын шаардлага хангасан зоорины хэмжээ 500 тонн нэмэгдэж аймгийн хүн амын хэрэгцээт:<br>Үр тариа 100% төмс 86% хүнсний ногоо 72%-ийг орон нутгийн үйлдвэрээр хангаж байна. Хөтөлбөрт давхардсан тоогоор 2 сумын 700 өрхөд ногооны үр, 87 иргэн, ААН-д хүлэмж олгон дэмжин ажилласан. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 10 дугаар тогтоолоор "Өрхийн тариалалтыг дэмжих" хөтөлбөр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллалаа. Өрхийн тариаланчдыг дэмжих замаар төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлийг хөгжүүлж, аймгийн хүн амын төмс, хүнсний ногооны хэрэгцээг жилийн турш, тогтвортой хангах зорилго тавин, төлөвлөгөөнд 9 арга | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэмжээ төлөвлөн 98 хувьтай хэрэгжсэн.<br>1. Хөнгөлөлттэй зээл: Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих хөнгөлөлттэй зээлд төмс, хүнсний ногооны үйлдвэрлэл эрхлэгч 16 иргэн 474.6 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгийн, 1 иргэн 35.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын зээлд хамрагдсан.<br>2. Үрийн дэмжлэг: Орон нутгийн төсвөөс 40.0 сая төгрөгийг батлуулан 5 төрлийн үрийн багцыг Баян-Өндөр сумын 26 багийн 500 өрхөд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас 80 хувийн хөнгөлөлттэй нөхцлөөр олгосон 13 төрлийн 2.6 тн үрийг 5 аж ахуйн нэгж, 230 өрх нийт 5 аж ахуйн нэгж, 730 өрхөд олгосон. Энэ аймгийн хэмжээний хүнсний ногооны тариалалтад шаардлагатай үрийн 30 хувийг хангаж байна. Үүний үр дүнд төмс 8 га талбайд тариалж 90 тонн ургац, хүнсний ногоо 140 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | га талбайд тариалж 2930 тонн ургац хураан авсан нь нийт төмсний ургацын 5 хувь, хүнсний ногоо ургацын 31 хувийг дэмжлэг болон хөнгөлөлттэй үрээр тариалан хураан аваад байна.<br>3. Улсын төсвийн хөрөнгөөр “Үйлдвэрлэгч баг” төслийн хүрээнд 90 ширхэг, “Шинэ хөдөө-Орхон” төслийн хүрээнд 10 ширхэг, нийт 100 ширхэг хүлэмжийг иргэн, аж ахуйн нэгжид олгосноор хүлэмжийн талбай 1.2 га талбайгаар нэмэгдсэн. Энэ онд хүлэмжийн тариалалт 5.1 га талбайд хийж 304 тонн ургац хураан авсан нь хүнсний ногооны нийт ургацад хамгаалагдсан хөрсний ургац 3.2 хувийг эзлэж байна. Энэ нь тайлант онд хүлэмжийн ургац өмнөх оноос 55 тонноор нэмэгдсэн үзүүлэлттэй байна.<br>4. Төмс, хүнсний ногооны талбайг хашаажуулах дэмжлэг: Орон нутгийн төсвийн 250 сая төгрөгийн хөрөнгөөр | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төмс, хүнсний ногооны талбайг хашаажуулахаар төлөвлөж, Жаргалант сумын Бөөн бургастад 3.6 км хашаа шинээр барьж, 36-р точикт 1.5 км хашааг сэргээн засварлахад нийт 234 сая төгрөгийг зарцуулсан. Үүний үр дүнд төмс, хүнсний ногооны тариалан эрхлэгч 49 иргэний эзэмшлийн 51 га талбайг хашиж хамгаалаад байна.<br>5. Зоорийн аж ахуйн дэмжлэг: Орон нутгийн төсвийн 3.4 тэрбум төгрөгийн хөрөнгөөр Жаргалант суманд төмс, хүнсний ногооны 500 тн багтаамжтай бүрэн механикжсан зоорь баригдаж байна.<br>Тус зооринд шаардагдах тоног төхөөрөмжийг шийдвэрлүүлэхээр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд санал хүргүүлснээр Дэлхийн банкны санхүүжилттэй “Экспортыг дэмжих” төслөөс манай аймагт | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Сэрээт өргөгч 1 ширхэг, модон хайрцаг 300 ширхэг, хуванцар хайрцаг 200 ширхэгийг олгосон.<br>6. Техник тоног төхөөрмжийн дэмжлэг:<br>Төмс, хүнсний ногооны техник шинэчлэлийн хүрээнд орон нутгийн төсвийн хөрөнгөөр 177.7 сая төгрөгийн трактор, техник, тоног төхөөрөмж, улсын төсвийн хөрөнгөөр 250.0 сая төгрөгийн трактор, хадуур, тармуур худалдан авсан. Үүний үр дүнд төмс, хүнсний ногооны үйлдвэрлэл эрхлэгч нарт хаврын тариалалт, арчилгаа, ургац хураалтын ажлыг технологийн хугацаанд хийж гүйцэтгэх боломж бүрдсэн. 2023 оны газар тариалангийн технологит 10 төрлийн ажил үйлчилгээг нийт давхардсан тоогоор 257 иргэнд үзүүлээд байна. Энэ нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 70 хувиар өссөн үзүүлэлттэй байна. | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Дөрөв. Ерөнхий чиг үүргийн нэр: Хүнсний салбарын чиглэлээр** | | | | | | | | |
| **4.1.Үндсэн чиг үүргийн нэр:** Хүнсний үйлдвэрлэл, хангамж, худалдааны бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах үндсэн үүрэг хүлээж, энэ хүрээнд хүнсний болон хоол үйлдвэрлэлд үнэ цэнийн болон кластерийн сүлжээг хөгжүүлэх, хүнс, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, импортыг орлох болон экспортлох боломжийг нэмэгдүүлэх, аймгийн хүн амын хүнсний хангамжийг тогтворжуулах, стратегийн хүнсний нийлүүлэлтийн улирлын хамаарлыг бууруулах, хүнсний сүлжээний бүх үе шатанд бүртгэл, чанарын удирдлага, хяналт, баталгаажуулалтын тогтолцоог бүрдүүлэх, бэхжүүлэх, мэдээллийн цахим санд мэдээлэх, чиг үүрэг хэрэгжүүлнэ. | | | | | | | | |
| Зорилт-1. Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг орон нутгийн үйлдвэрлэлээр хангана. /ЗГҮАХХАХТ-ийн 3.3.3/, /ЗДҮАХ-ийн 4.2./ | Арга хэмжээ-1: “Эрүүл Хүнс-Эрүүл Монгол Хүн” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж хүн амын хүнсний хэрэгцээт мах, төмс, гурилыг бүрэн, хүнсний ногооны 50-аас доошгүй хувийг орон нутгийн үйлдвэрлэлээс хангах | Хангамжийн хувиар тооцно. | Хангамж /хувь/: Малын мах-90.7, сүү-45.3, гурил- 0.7, Төмс-100, хүнсний ногоо-72.6, жимс, жимсгэнэ-0.1 | 2021 онд: Хангамж: Малын мах-92.0, сүү-50.0, гурил-10.0, Төмс-100, хүнсний ногоо-60.0, жимс, жимсгэнэ-0.2<br>2022 онд: Хангамж:Малын мах-94.0, сүү-50.0, гурил-15.0, Төмс-100, хүнсний ногоо-65.0, жимс, жимсгэнэ-0.3<br>2023 онд: Хангамж: Малын мах-94.0, сүү-55.0, гурил-20.0, Төмс- | Эх үүсвэр: Орон нутгийн төсөв Нийт: 75.0 сая.төг 2021 онд: 25.0 2022 онд: 25.0 2023 онд: 25.0 2024 онд: - | 2021 онд аймгийн хэмжээнд хүнсний чиглэлийн 85 үйлдвэр цех үйл ажиллагаа явуулж 2021 оны хүн амын хэрэгцээт малын махны 90,7% сүүг 100%. цагаан идээний 10,9%, гурил 0,7%, гурилан бүтээгдэхүүний 23,6%. жимс жимсгэнийн 0,2%, төмс 100%, хүнсний ногооны 73%-ыг орон нутгийн дотоодын үйлдвэрлэлээр хангаж байгаа бол шингэн сүүний 2,7%, цагаан идээний 9,9%-ыг үйлдвэрийн аргаар боловсруулсан бүтээгдэхүүнээр хангаж байна. 2022 оны хүн амын физиологийн хэрэгцээг тооцоход: Малын мах-3714,4 тн, сүү-4952,6 тн, Цагаан идээ-5571,6 тн, гурил-3095.3 тн, гурилан бүтээгдэхүүн-5571,6 тн, | 100 | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 100, хүнсний ногоо-70.0, жимс, жимсгэнэ-0.3 | | төмс-3714,4 тн, хүнсний ногоо-8047,9 тн, жимс-6190,7 тн, өндөг-619.0 тн, хэрэгцээтэйгээс малын махны 92.7% гурил 0%. гурилан бүтээгдэхүүний 34,5%, Жимс жимсгэнийн 0,3% төмсийг 86,5%, хүнсний ногооны 72%, өндөгний 2.3%-ийг орон нутгийн дотоодын үйлдвэрлэлээр хангаж байгаа бол шингэн сүүний 2,7%, цагаан идээний 5,4%-ийг үйлдвэрлэлийн аргаар боловсруулсан бүтээгдэхүүнээр хангасан. Энэ нь өмнөх оноос мах, 0.7 цагаан идээ 4.5 гурилан бүтээгдэхүүн 10,9 Хүнсний ногоо 12 Жимс жимсгэнийн 0,1%-аар өссөн бол төмсний хангамж 13,5 Гурил 0,7%-аар буурсан нь төмсний тариалалт багассан бол гурилын үйлдвэрлэл тогтвортой явагдаагүй нь нөлөөлсөн байна. “Эрүүл хүнс- Эрүүл монгол хүн” үндэсний хөтөлбөр нь Монгол Улсын Засгийн | | |
| | | | | 2024 онд: Хангамж: Малын мах-95.0, сүү-55.0, гурил-40.0, Төмс-100, хүнсний ногоо-75.0, жимс, жимсгэнэ-0.3 | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | газрын 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 314 дүгээр тогтоолоор хүчингүй болсон. Монгол Улсын Их хурлын 2022 оны 36 дугаар тогтоолоор батлагдсан. “Хүнсний хангамж , аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөнийг Орхон аймагт 2022-2027 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аймгийн ИТХ-ын 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 12/02 дугаар тогтоолоор батлуулж 23 зорилтын хүрээнд 49 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. 2023 онд ХХААГ-аас тус төлөвлөгөөний хүрээнд зохион байгуулалтын 10 ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөж арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах 52.000.000 (тавин хоёр сая) төгрөгийг орон нутгийн төсөвт тусган батлуулж хэрэгжилийг ханган ажиллаж байна. 2023 аймгийн хүн амын хэрэгцээт малын махны | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 60.2, сүүний 4.0, цагаан идээний 4.6, гурилан бүтээгдэхүүний 42.6, улаан буудай 100.0, төмсний 43.3, хүнсний ногоо 100.0 хувь тус тус орон нутгийн үйлдвэрлэлээр хангаж байгаа нь өмнөх оны мөн үеэс махны хангамж 8.9 хувиар, сүүний хангамж 48.1 хувиар, цагаан идээний хангамж 35.3 хувиар, гурилан бүтээгдэхүүний хангамж 0.2 хувиар өссөн бол төмс 61.7, хувиар, хүнсний ногоо 3.9 хувиар тус тус буурсан байна. | | |
| | Арга хэмжээ-2: Хаврын хүнсний улирлын нөөц бүрдүүлэх зорилгоор махны нөөц бүрдүүлэх | Хаврын хэрэгцээт махны хувь, бэлтгэсэн мах /тн/ | Хаврын хэрэгцээт махны 25%-буюу 301.1 тн мах бэлтгэсэн. | 2021 онд: 50-аас доошгүй хувийг хангана.<br>2022 онд: 50-аас доошгүй хувийг хангана.<br>2023 онд: 120.0 мян.тн<br>2024 онд: 50-аас доошгүй | Эх үүсвэр: Орон нутгийн төсөв Нийт: 2.200.0 сая.төг 2021 онд: 400.0 2022 онд: 600.0 2023 онд: 600.0 2024 онд: 600.0 | гүйцэтгэлээр олгосон. 2021 онд хаврын улирлын хэрэгцээний 25% буюу 300 тонн малын махыг бэлтгэн хадгалж, худалдаанд нийлүүлэх гэрээг аймгийн ЗДТГ Жаргалант мах импекс ХХК, Эрдмийт ХХК,Эрдэнэт мах маркет ХХК-ийн махны үйлдвэртэй байгуулсан. Нөөцийн махыг 3 дугаар сарын 15-ны өдрөөс 6 дугаар сарын 15-ны | 70 | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хувийг хангана. | | өдрийг хүртэл хугацаанд ангилан савласан 1кг үхрийн мах 8200 төгрөг, ангилан савласан 1кг хонины мах 6900 төгрөг, ангилан савласан 1кг ямааны мах 6200 төгрөгөөр нийт 33 цэгээр борлуулсан. Нөөцийн махыг зах зээлийн махны үнээс 2200-3800 төгрөгийн хямдаар борлуулсан. Орон нутгийн төсвөөс бэлтгэн нийлүүлсэн махны 1кг тутамд 1300 төгрөг буюу нийт 390 сая төгрөгийг урамшууллыг үйлдвэрүүдэд гэрээний гүйцэтгэлээр олгосон. 2022 онд хаврын хэрэгцээнд 150 тонн үхэр, хонь, ямааны мах бэлтгэх хадгалах худалдаанд нийлүүлэх гэрээг аймгийн ЗДТГ-аас Эрдэнэт Мах маркет ХХК-тай гэрээг байгуулж, энэ оны 3 сарын 15-ны өдрийн 6 сарын 5-ны өдрийг хүртэл хугацаанд ангилсан савласан 1кг Үхрийн мах 7800 төгрөг, хонины мах 6800 төгрөг, ямааны мах 5800 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төгрөгөөр нийт 31 цэгээр борлуулсан. Энэ нь хүн амын хаврын хэрэгцээт махны 20%-ийг хангасан. Нөөцийн махыг зах зээлийн махны үнээс үхрийн мах 5700, хонины мах 5200, ямааны мах 4200, Нийслэлийн нөөцийн махны үнээс үхрийн мах 1100, хонины мах 1500, ямааны мах 1300 төгрөгөөр хямдаар борлуулсан. Орон нутгийн төсвөөс ААН-ийн бэлтгэн нийлүүлсэн 1кг маханд 2000 төгрөг буюу 300 сая төгрөгийг гэрээний гүйцэтгэлээр олгосон. Орон нутгийн төсвөөс нөөцийн мах бэлтгэн худалдаанд гаргаагүй ч “Өвлийн идэш” арга хэмжээнд оролцож, иргэд 63.5 тонн малын мах худалдан авснаар өвлийн идшээ хямд нөөцлөх боломж бүрдсэн. Мөн аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 3 махны үйлдвэр өөрсдийн нэрийн дэлгүүрээр 150 тн мах зах зээлд нийлүүлснээр 2023 оны хаврын улиралд аймгийн | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэмжээнд махны хомсдол үүсээгүй. Аймгийн хүн амын 2024 оны хаврын улирлын махны хэрэгцээнд 200 тн мах бэлтгэнэ. Нөөцийн мах бэлтгэн нийлүүлэх аж ахуйн нэгжийг нээлттэй сонгон шалгаруулсан. | | |
| Зорилт-2. Хүнсний сүлжээний бүх шатанд түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангана. /ЗГҮАХХАХТ-ийн 3.3.3/, /ЗДҮАХ-ийн 4.3./ | Арга хэмжээ-1: Давсны хэрэглээг бууруулах үндэсний стратегийн хэрэгжилтийг хангаж ажиллах хүрээнд хүнс, хоол үйлдвэрлэл эрхлэгчдэд давсны агууламжийг бууруулах талаар мэргэжил арга зүйн зөвлөмж өгч сургалт мэдээллээр хангаж ажиллах | Давсны агууламжийн хувь | Бүтээгдэхүүний давсны агууламж 47.9 хувиар буурсан. | 2021 онд: -<br>2022 онд: Бүтээгдэхүүний давсны агууламж 50.0 хувиар буурна.<br>2023 онд: Бүтээгдэхүүний давсны агууламж 53.0 хувиар буурна.<br>2024 онд: Бүтээгдэхүүний давсны агууламж 56.0 хувиар буурна. | Эх үүсвэр: Орон нутгийн төсөв Нийт: 15.0 сая.төг 2021 онд: - 2022 онд: 5.0 2023 онд: 5.0 2024 онд: 5.0 | 2021 онд: аймгийн хэмжээнд үйл ажиллагаа ажиллагаа явуулж буй хүнсний үйлдвэрийн 80% хоол үйлдвэрлэлийн 55% нь шим тэжээлийн үзүүлэлт, мах махан бүтээгдэхүүн үйлдвэрлэлчийн 30% нь давсны агууламжийг хүнсний бүтээгдэхүүний шошго, хоолны цэсэнд тусгаж хэвшсэн. Хоол үйлдвэрлэл эрхлэгчдийн технологийн мөрдүүлэх зорилгоор хоолны илчлэг тооцох, технологийн карт боловсруулах 2 төрлийн 216 ширхэг зөвлөмжийг бэлтгэн хоол үйлдвэрлэл эрхлэгчдэд хүргүүлэн мөрдүүлэн ажиллаж байна.2022 онд сургууль, цэцэрлэг, эмнэлэг, сувиллын | 90 | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгууллагуудын эмч, хоол зүйч нарт давс, саахар чихрийн хэрэглээг бууруулах хэрэглэгчдэд эрүүл шим тэжээллэг хүнс, хоол олгох, хэвшил болгох талаар 3 удаагийн сургалтыг үе шаттай зохион байгуулж, нийт 84 мэргэжилтнийг хамруулсан. Мөн хүн амд хоол тэжээлийн боловсрол олгох сургагч багшаар 152-аар хүнийг бэлтгээд байна. Сургууль, цэцэрлэг, эмнэлэг, сувилалын хоол, үйлдвэрлэлийн хоногт хүнс тэжээлээс авах давсны зохист харьцааг мөрдүүлснээр агууламжийг 50%-аар бууруулж зохист хэмжээнд хүргэсэн үр дүнтэй байна. Хүнсний боловсруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 15 үйлдвэр, цехэд үйлдвэрлэж буй бүтээгдэхүүний давсны орц найрлагыг бууруулах зөвлөмж мэдээлэл хүргүүлж ажилласан. Энэ онд түүврийн аргаар орон нутагт | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үйлдвэрлэдэг 8 хүнсний бүтээгдэхүүн, хоол үйлдвэрлэлийн 9 дээж авч давсны агууламжийг тодорхойлоход бүгд зохист хэмжээнд хэрэглэж хэвшснээс гадна бүтээгдэхүүний давсны агууламжийг өмнөх оноос 51.8 хувиар бууруулсан байна. | | |
| | Арга хэмжээ-2: Хүнсний бүтээгдэхүүний чанар, стандартын талаар үйлдвэрлэгчдийн мэдлэгийг дээшлүүлэх | Сургалтад хамрагдсан үйлдвэрлэл эрхлэгчдийн тоо | 20 үйлдвэрлэл эрхлэгчийг чанар стандартын сургалт хамруулсан. | 2021 онд: -<br>2022 онд: 20 үйлдвэрлэл эрхлэгч<br>2023 онд: 20 үйлдвэрлэл эрхлэгч<br>2024 онд: 20 үйлдвэрлэл эрхлэгч | Эх үүсвэр: Орон нутгийн төсөв Нийт: 6.0 сая.төг 2021 онд: - 2022 онд: 2.0 2023 онд: 2.0 2024 онд: 2.0 | Аймгийн Стандарт хэмжилзүйн хэлтсээс "Хүнсний бүтээгдэхүүний чанар аюулгүй байдлын шаардлагыг Шар тогтоосон эрх зүйн зохицуулалтууд" сертификаттай 8 цагийн сургалтыг зохион байгуулж, нийт 18 үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчийг хамруулан анхны шатны мэдлэгийг олгосон. Монгол ногоо төслөөс орон нутгийн газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдэд ХАА-н зохистой дадал нэвтрүүлэх сургалтыг зохион байгуулж 35 өрхийн тариаланчийг хамруулан мэдлэг олгосон. Үүний үр дүнд өвлийн хүлэмжийн 1, ил талбайн хүнсний | 100 | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ногооны 1 нийт 2 өрхийн тариаланчийг үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг баталгаажуулалтанд хамруулан баталгаажуулж, манай аймагт ХХАА-н зохист дадал нэвтрүүлсэн үйлдвэрлэл 5 болж нэмэгдсэн. Эрдэнэт мах маркет ХХК махны үйлдвэр 7 удаагийн сургалтаар 202 ажилтныг сурган чадавхжуулж, 2022 оны 9 сард Хүнсний аюулгүй байдлын чанарын удирдлагын тогтолцоо ISO 9001-ийн 2дах удаагийн давтан баталгаажилтад амжилттай хамрагдан баталгаажилт авсан. Ингэснээр олон улсын хүнсний аюулгүй байдлын стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, бүтээгдэхүүн үйлчилгээнийхээ үнэ цэнийг батламжлав. 2023 онд хүнсний үйлдвэрлэл эрхлэгчдийг хүнсний аюулгүй байдлын талаарх хууль эрх зүйн мэдлэг | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | салбарын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх чадавхижуулах 1 сарын хөтөлбөрт сургалтыг BEST хөтөлбөр, Обзерв Консалтинг хүнсний аюулгүй байдлын зөвлөх байгууллагатай хамтран зохион байгуулж, хүнсний боловсруулах 35 үйлдвэр, цехийг нийт 5 удаагийн сургалтад хамруулан мэдлэг олгон сертификат гардуулав. | | |
| | Арга хэмжээ-3: Тохирлыг илэрхийлэх чанар, аюулгүй байдлын тэмдэгтэй бүтээгдэхүүн бий болгох замаар өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх | Аюулгүй байдлын тэмдэгтэй бүтээгдэхүүн бий болсон байна. | - | 2021 онд: -<br>2022 онд: Аюулгүйн тэмдэгтэй бүтээгдэхүүний эзлэх хувь 3%<br>2023 онд: Аюулгүйн тэмдэгтэй бүтээгдэхүүний эзлэх хувь 5%<br>2024 онд: Аюулгүйн тэмдэгтэй бүтээгдэхүүний эзлэх хувь 5% | Эх үүсвэр: Орон нутгийн төсөв Нийт: 9.0сая.төг 2021 онд: - 2022 онд: 3.0 2023 онд: 3.0 2024 онд: 3.0 | 2021 онд: аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дэргэд "Бүтээгдэхүүн, үйлчилгээний баталгаажуулалтын орон тооны бус зөвлөл" ийг 5 хүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулж, тохирлын үнэлгээний дүнг үндэслэн 1-3 жилийн хугацаатай тохирлын гэрчилгээ олгох шийдвэр гарган ажиллаж байна. Хүнсний 8 нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч 10 үйлдвэр, хоолны газар, 5 нэр төрлийн үйлчилгээ эрхлэгч, 8 аж ахуйн нэгж, | 100 | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүнсний худалдааны 2 нэр төрлийн үйлчилгээ эрхлэгч 84 ААН, 4 иргэний бүтээгдэхүүн үйлчилгээнд тохирлын гэрчилгээ олгосноос "Тэмүүжин-Оргил" ХХК-ийн. бүтээгдэхүүний үйл явц, тохирлын үнэлгээний дүнд "Бүрэн хангалттай" үнэлгээ авч, тохирлын гэрчилгээний хугацааг 3 жилээр сунгасан. Тус компанийн талхан бүтээгдэхүүний 2 нэр төрлийн жигнэмэл гурилан бүтээгдэхүүний 1 нэр төрөлд баталгаажсан бүтээгдэхүүний тэмдэг хэрэглэх эрх олгож, гэрээ байгуулсан. 2022 онд "Бүтээгдэхүүн, үйлчилгээний баталгаажуулалтын орон тооны бус зөвлөл" нь 9 удаа хуралдаж, 84 ААН иргэний малын мах, бялуун бүтээгдэхүүн, хүнсний худалдаа, хоол үйлдвэрлэлийн 82 үйлчилгээнд тохирлын үнэлгээ хийж, баталгаажуулалтад хамруулан, стандартын хэрэгжилтийн түвшинг | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дээшлүүлэх шаардлагатай ААН-д залруулах арга хэмжээг хэрэгжүүлэн, заавар зөвлөмжөөр хангаж, үл тохирлыг арилгуулан ажилласан. МХГ ХХААГ-ын хамтран ХАА-н зохистой дадлын баталгаажуулалтыг хийлгэхээр гэрээ байгуулсан газар тариалангийн үйлдвэрлэл эхлэгч 2 иргэний тариалсан 12 нэрийн бүтээгдэхүүнээс дээж авч, нитрит болон пестицидийн үлдэгдэл тодорхойлуулах шинжилгээг хийлгэж шинжилгээний дүнг Монгол ногоо төсөлд хүргүүлсэн. 2023 онд “Бүтээгдэхүүн үйлчилгээний баталгаажуулалтын орон тооны бус зөвлөл”-ийн шийдвэрээр “Баталгаажсан бүтээгдэхүүн” тэмдгийг катодын зэсийн 1, талх, нарийн боовны 1 үйлдвэрийн 4 төрлийн 19 нэрийн бүтээгдэхүүн, нийт 7 үйлдвэрийн 16 нэр төрлийн 44 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бүтээгдэхүүнд хэрэглэх эрх олгоод байна. /10.4 хувь/ Аюулгүйн тэмдгийн талаар мэдлэг ойлголтыг 95 хүнсний үйлдвэрлэл, худалдаа эрхлэгчдэд өгч мэдээллийн самбарт нь зурагт хуудсаар байршуулж нийтэд сурталчлах ажлуудыг хийлээ. Аюулгүйн тэмдэгтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэх техникийн зохицуулалтын шаардлагыг хангаж тохирлын баталгаажуулалтад хамрагдсанаар “Жүр үр” ХХК аюулгүйн тэмдгийг бялуун бүтээгдэхүүний 12 нэрийн бялуун бүтээгдэхүүнд хэрэглэх эрхийг авч нийт бүтээгдэхүүний 2.9 хувь нь аюулгүйн тэмдэгтэйгээр зах зээлд нийлүүлэгдэж байна. | | |
| **Тав.Ерөнхий чиг үүргийн нэр: Хөнгөн үйлдвэрлэлийн салбарын чиглэлээр** | | | | | | | | |
| **5.1.Үндсэн чиг үүргийн нэр:** Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг ханган ажиллах үндсэн үүрэг хүлээж, энэ хүрээнд хөнгөн үйлдвэрийн салбарт экспортын баримжаатай болон импортыг орлох бүтээгдэхүүний нэр, төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэх, үнэ цэнийн болон кластерын сүлжээг хөгжүүлэх бодлогын хэрэгжилтийг хангах, хөнгөн үйлдвэрийн инноваци, технологийн шинэтгэлийг эрчимжүүлэх ажлыг зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ. | | | | | | | | |
| Зорилт-1. Орон | Арга хэмжээ-2: | Хөтөлбөр хэрэгжилтий | - | 2021 онд: Хөтөлбөрий | Эх үүсвэр: Орон | 2021 онд Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх | 100 | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| нутгийн нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний борлуулалтыг дэмжинэ. /ЗГҮАХХАХТ-ийн 3.3.12/, /ЗДҮАХ-ийн 7.2.3./ | “Өрхийн болон бичил үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх | н хувиар тооцно. | | н хэрэгжилт 15%<br>2022 онд: Хөтөлбөрийн хэрэгжилт 30%<br>2023 онд: Хөтөлбөрийн хэрэгжилт 30%<br>2024 онд: Хөтөлбөрийн хэрэгжилт 30% | нутгийн төсөв, төсөл хөтөлбөр Нийт: -<br>2021 онд: -<br>2022 онд: -<br>2023 онд: -<br>2024 онд: - | сангаас ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг үйлдвэрээ өргөтгөх хүчин чадлаа нэмэгдүүлэх төслөөр хөнгөлөлттэй зээл авсан. "Энундрам үйлс" ХХК, "Мөнх баян алт" ХХК-д Хонь тэмээний ноосыг анхан шатны боловсруулалтаас эхлэн эцсийн бүтээгдэхүүн болгон зах зээлд нийлүүлж байна. Иргэн Н.Мөнхдөл нэхий, арьс ширийг боловсруулан гутлын улавчийг размер тус бүрээр хийн зах зээлд гаргасан бөгөөд дотоодын цэргийн 186 дугаар ангид 5000 ширхэг нэхий улавч нийлүүлэн хамтран ажиллаж байна. Малын арьс ширийг анхан шатанд нь зөв, эсгэлтгүй хуулах, хонины ноос хяргах зөвлөмжийг давхардсан тоогоор 120 малчин өрхөд, ХХААХҮЯ-наас гаргасан арьс шир хуулах төхөөрөмжийн гарын авлагыг 40 малчинд хүргэж арга зүйн зөвлөмж өгсөн. Эрдэнэт | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үйлдвэр 3 худалдааны цэг, сагс, цахим дэлгүүрээр дамжуулан бизнес эрхлэгчдэд 974,5 Сая төгрөгөөр борлуулалтын орлогыг нэмэгдүүлсэн байна. Мөн орон нутгийн худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг худалдан авах урилга гаргаснаар нийт 2097 иргэн ААН 232.1 Тэрбум төгрөгийн гэрээ байгуулан ажилласан байна. 2022 онд: 6 удаагийн үзэсгэлэн худалдаа зохион байгуулах бизнес эрхлэгчдийн оролцуулах ажлыг зохион байгуулж давхардсан тоогоор 4700 гаруй хүн үзэж сонирхоно 192.2 сая төгрөгийн борлуулалт хийсэн.<br>Цагаан сар-2023, Хаврын гоёл-2023, “Намрын ногоон өдрүүд-Үндэсний үйлдвэрлэл” нэгдсэн арга хэмжээ, Эрдэнэтэд үйлдвэрлэв–2023, ITM аялал жуулчлал, Эрдэнэт түншлэл-2023 үзэсгэлэн | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | худалдаа зэрэг нийт 6 удаагийн арга хэмжээнд давхардсан тоогоор 300 гаруй жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийг оролцуулж 200.0 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна. Дээрх үзэсгэлэн арга хэмжээнээс онцлох бараа бүтээгдэхүүний уралдаан зарлаж шинэлэг, шинэ бүтээгдэхүүний номинацид “Ширмэг цүнх” ХХК-ны үхрийн арьсаар хийсэн эрэгтэй костюмны гэр, “Орхон хаан сүлжмэл” ХХК-ны ноолууран хувцасны коллекци, импорт орлох экспортын баримжаатай бүтээгдэхүүн номинацид “Саран үйлс” ХХК-ны үндэсний болон европ загварын дээл хувцас, эрүүл мэндэд ээлтэй хүнсний бүтээгдэхүүнээр “Ачит андага” ХХК -ны артишокны ундаа, “Хантай баян” ХХК-ны халтар арвайн гурил тус тус шалгарч Өргөмжлөл мөнгөн шагналаар шагнагдсан. Намрын ногоон өдрүүд-Үндэсний | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үйлдвэрлэл үзэсгэлэн худалдаанд хөнгөн үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний “Загварын шоу”-г зохион байгуулж “Урлахуйн жигүүр” ХХК Нэг суурин-Нэг бүтээгдэхүүн аяны шилдэг оролцогчоор шалгаран өргөмжлөл мөнгөн шагналаар шагнагдсан зэрэг олон амжилтуудыг гаргасан. | | |
| Зорилт-2. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулах үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлнэ. /ЗГҮАХХАХТ-ийн 3.3.12/, /ЗДҮАХ-ийн 7.2.4./ | Арга хэмжээ-1: Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулах үйлдвэрийг зээлийн бодлогоор дэмжин ажиллах | Зээлийн бодлого, дэмжлэгийн мөнгөн дүн | 7 төсөл 481.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамрагдсан. | 2021 онд: 500.0 сая төгрөгийн зээлд хамруулна.<br>2022 онд: 500.0 сая төгрөгийн зээлд хамруулна.<br>2023 онд: 500.0 сая төгрөгийн зээлд хамруулна.<br>2024 онд: 500.0 сая төгрөгийн зээлд хамруулна. | Эх үүсвэр: Улсын төсөв болон орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр Нийт: -<br>2021 онд: -<br>2022 онд: -<br>2023 онд: -<br>2024 онд: - | 2021 онд: Монгол Улсын ЗГ-аас хэрэгжүүлж буй ХАА-н үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 14-н ААН 194 иргэнд 2.5 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон байна. Сум хөгжүүлэх сангаас ХАА-н чиглэлээр 7 иргэн 61.0 Сая төгрөг, боловсруулах үйлдвэрлэлийн чиглэлээр 5 иргэн, ААН-д 60 сая төгрөгийг хөнгөлөлттэй зээлээр дэмжсэн. 2022 онд: ХАА-н үйлдвэрлэлийг дэмжих хөнгөлөлттэй зээлийг хөтөлбөрт 9 ААН, 53 иргэн хамрагдаж нийт | 100 | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 4,3 Тэрбум төгрөгийн зээл олгогдсон. -ЖДҮХС-ийн хөнгөлөлттэй зээлд 2 ААН хамрагдаж 194,3 сая төгрөгийн санхүүжилт авсан. Баян-Өндөр сумын хоршоо хөгжүүлэх сангаас 1 хоршоо, 5 аж ахуй нэгжид 230.0 сая төгрөгийн зээл олгосон. Эдгээр санхүүжилтийн үр дүнд 70 иргэн, аж ахуйн нэгж 4.7 тэрбум төгрөгийн санхүүжилт авсан. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 5 аж ахуйн нэгжийн төсөл шалгарч 894.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл авсан.<br>Хөнгөлөлттэй зээлд хамрагдснаар сүүний үйлдвэр хөргөлтийн автомат төхөөрөмжтэй болж үйлдвэрийн үйл ажиллагааны урсгал шугамыг стандарт хэмжээгээр зохион байгуулсан.<br>Бүтээгдэхүүний сав баглаа боодол, хаяг шошгоо шинэчилсэн. Махны 2 үйлдвэр үйлдвэрийн байраа | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | өргөтгөж, хөргөлтийн системийг бүрэн шийдвэрлэсэн. Мөн газар тариалангийн чиглэлээр 1, оёдлын үйлдвэрийн чиглэлээр 1 аж ахуйн нэгж зээлд хамрагдсан.<br>Монгол улсын Засгийн газраас хэрэгжүүлсэн хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих хөнгөлөлттэй зээлээс 24 аж ахуйн нэгж, 18 иргэнд 14.2 тэрбум төгрөгийн санхүүжилт авсан.<br>Баян-Өндөр, Жаргалант сумдын Хоршоо хөгжүүлэх сангаас 27 аж ахуйн нэгж, хоршоо, иргэнд 533.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон. Зээлд хамрагдсан иргэн, аж ахуйн нэгжүүд тоног төхөөрөмжөө шинэчилж, 54 ажлын байрыг шинээр бий болгосон байна. | | |
| **Зургаа.Ерөнхий чиг үүргийн нэр: Жижиг дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршооны чиглэлээр** | | | | | | | | | |
| **6.1.Үндсэн чиг үүргийн нэр:** Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршоо, ахуйн үйлчилгээний салбарын санхүүгийн болон санхүүгийн бус дэмжлэгийн бодлогын хэрэгжилтийг хангах чиг үүрэг хүлээнэ. | | | | | | | | | |
| Зорилт-1. Орон нутгийн нэмүү өртөг | Арга хэмжээ-1: “Эрдэнэт үйлдвэрлэл” | Хөтөлбөр хэрэгжилтийн хувиар тооцно. | Хөтөлбөрийн хэрэгжилт 70% | 2021 онд: Хөтөлбөрийн хэрэгжилт 100% | Эх үүсвэр: Орон нутгийн төсөв, | 2018-2021 онд хэрэгжих Эрдэнэт үйлдвэрлэл хөтөлбөрийн 2 зорилт 11 дэд зорилт 27 | 100 | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| шингэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний борлуулалтыг дэмжинэ. /ЗГҮАХХАХТ-ийн 3.3.12/, /ЗДҮАХ-ийн 7.2.3./ | хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх | | | 2022 онд: Хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж хэрэгжүүлнэ. Хэрэгжилт 20%<br>2023 онд: Хэрэгжилт 50%<br>2024 онд: Хэрэгжилт 100% | төсөл хөтөлбөр Нийт: 191.0 сая.төг 2021 онд: 41.0 2022 онд: 50.0 2023 онд: 50.0 2024 онд: 50.0 | хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд нийт 102.2 сая төгрөгийн зарцуулж хөтөлбөр 94.4 хувьтай хэрэгжсэн. Хөтөлбөрийн үр дүнд: Боловсруулах үйлдвэрлэлийн салбарын үйлдвэр 15.1 хувь, борлуулалтын орлого 32.9 хувь, ажлын байр 8.1 хувиар тус тус өсч, хүүгүй барьцаагүй хөнгөлөлттэй зээлийн шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг гарган 218 өрхийн бизнес эрхлэчийг нийт 630.0 сая төгрөгийн зээлээр дэмжсэн, аймгийн Засаг даргын тамгын газраас олгодог хөнгөлөлттэй зээлийн хүүгийн хэмжээг жилийн 12 хувь байсныг 10 хувь болгон бууруулсан. Олон улсын байгууллагын 2 төслийг орон нутагт хэрэгжүүлэн чадавхжуулах 65 удаагийн сургалт хэлэлцүүлэг хийж 1007 бизнес эрхлэгчдийг хамруулж 208 бизнес төсөлд зөвлөх үйлчилгээ үзүүлж 6.7 тэрбум төгрөгийн зээлийн | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зуучлалын үйлчилгээг үзүүлж , 6 бизнес эрхлэгч, ТББ-ыг 85.5 сая төгрөгийн буцалтгүй тусламжинд хамруулан ажилласан. Төрийн байгууллагаас олгогдож буй хөнгөлөлттэй зээлүүдийн уялдаа холбоог сайжруулах, нэгдсэн мэдээллээр хангах үйл ажиллагааг нэвтрүүлэн ажиллаж тайлант хугацаанд төрийн байгууллагаас 485 бизнесийн төсөлд 9.6 тэрбум төгрөгийн зээлийг бизнес эрхлэгч дэд олгож 1940 ажлын байр хадгалагдаж 972 шинэ ажлын байр бий болсон байна. Эрдэнэт үйлдвэрлэв 3 худалдааны цэг, сагс цахим дэлгүүр 974.5 сая төгрөгийн борлуулалт хийгдсэн. Мөн орон нутгийн худалдаа үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг худалдан авах уриалга гаргаснаар нийт 2097 иргэн аж ахуйн нэгж 232.1 тэрбум төгрөгийн гэрээ байгуулан | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажилласан байна. ШУТП ОНӨҮГ-ын дэргэд Бизнес хөгжлийн төвийн байгуулснаар Бизнес эрхлэгчдийн дундын оффис, олон улсын эрхтэй хөгжлийн сургалт, арга хэмжээ 8-ыг шинээр бии болгон ажилласан тоогоор бизнесийн хөгжлийн сургалт , үйлчилгээг 1080 иргэнд хүргэж, менежментийн зөвлөн туслах үйлчилгээгээр 20 бизнесийг хөгжүүлж 18 бизнесийг ажлын байраар ханган хөгжүүлж, 150 иргэнийг мэргэжлийн ур чадварт сурган ажлын байранд зуучилсан байна. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны X ралдаанаар “Эрдэнэт үйлдвэрлэл” дэд хөтөлбөр батлагдсан Тус хөтөлбөр нь 2018-2021 онд 94.4 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжсэн. Тус хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр “Өрхийн болон бичил үйдвэрлэл, үйлчилгээг дэмжих | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хөтөлбөр"-ийг аймгийн ИТХ-ын 2023 оны 14/02 дугаар тогтоолоор батлуулан ажиллаж байна. | | |
| Зорилт-2. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг гадаад, дотоодын төсөл, хөтөлбөрт хамрагдаж хөнгөлөлттэй зээл, батлан даалтын үйлчилгээ авахад дэмжлэг үзүүлнэ. /ЗГҮАХХАХТ-ийн 3.3.13/, /ЗДҮАХ-ийн 7.2.1./ | Арга хэмжээ-1: Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг хөнгөлөлттэй зээлд хамруулах | Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээнд олгосон зээлийн хэмжээ | 1.3 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон. | 2021 онд: Хөнгөлөлттэй зээлд хамруулсан байна.<br>2022 онд: Хөнгөлөлттэй зээлд хамруулсан байна.<br>2023 онд: Хөнгөлөлттэй зээлд хамруулсан байна.<br>2024 онд: Хөнгөлөлттэй зээлд хамруулсан байна. | Эх үүсвэр: Улсын төсөв<br>Нийт: -<br>2021 онд: -<br>2022 онд: -<br>2023 онд: -<br>2024 онд: - | 2021 онд: Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хөнгөлөлттэй зээлээс 209 аж ахуйн нэгж, 682 иргэн нийт 891 зээлдэгч 60.5 тэрбум төгрөг, РЕПО санхүүжилтийн зээлээс 133 зээлдэгч 26.0 тэрбум төгрөг, Хөдөө аж ахуйг дэмжих зээлээс 14 ААН, 194 иргэн 2.5 тэрбум төгрөг, нийт 1212 зээлдэгчид 89.0 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгож 4576 ажлын байр хадгалагдасан байна. Сум хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээлд нийт 633.5сая төгрөгийн санхүүжилт хүссэн 58 төсөл хүлээн авч 37 төсөлд 398 сая төгрөгийн зээлийг олгосон байна. Аймгийн жижиг, дунд үйлдвэр болон өрхийн бичил үйлдвэрлэлийг дэмжих "Тусгай зориулалтын сан"-аас 2021 онд 194,0 сая төгрөгийн 7 төслийг | 100 | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дэмжин ажилласан. "Гарааны бизнес -2021" төслийн хүрээнд нийт 40 иргэн, аж ахуйн нэгжид хүүгүй барьцаагүй 340,0 сая төгрөгийн хөнгөлөлтэй зээлийг олгосон. 2022 онд: Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөрөөс 9 ААН-д 3.1 тэрбум , 53 иргэн 1.2 тэрбум буюу нийт 62 иргэн аж ахуйн нэгжид 4.3 тэрбум төгрөгийн зээл олгогдсон. Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас сүүний сангаас сүүний чиглэлийн үхрийн фермийн аж ахуй, шахмал хавтангийн үйлдвэр байгуулах 2 аж ахуйн нэгжид 194.3 сая төгрөгийн зээл олгосон.<br>-Аймгийн жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих хөнгөлөлттэй зээлд нэг ААН хамрагдаж 50 сая төгрөгийн зээл хоршоо хөгжүүлэх сангийн зээл зөгийн аж ахуй, халтар арвай мод үржүүлгийн | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | чиглэлийн 5 ААН, Нэг хоршоо хамаарагдаж 230 сая төгрөгийн санхүүжилт хөдөлмөр эрхлэгчтийг дэмжих сангаас "Эрдэнэтчүүд Эрдэнэтчүүддээ хайртай" хөтөлбөрийн "Гарааны бизнес-2022" арга хэмжээг зохион байгуулж 36 иргэн ААН-ийн төслийг сонгон шалгаруулж 270 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус олгосон. Нийт 107 иргэн ААН-д 5 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байна. 2023 онд Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн зээлд хамрагдахаар 1_7 тэрбум төгрөгийн санхүүжилт хүссэн 11 төсөл цахим системд ирүүлснийг хүлээн авч журмын дагуу судлан аймгийн дэд хороогоор хэлэлцүүлэн 70-с дээш оноо авсан 5 төсөлд 894.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон. Сумдын хоршоо хөгжүүлэх сангаас 27 иргэн, аж ахуйн нэгжид 533.0 сая төгрөгийн зээл олгосон. Монгол улсын | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Засгийн газраас хэрэгжүүлсэн хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөрийн хүрээн 22 аж ахуйн нэгж, 18 иргэнд 14.2 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгогдоод байна. Арилжааны банкаар дамжуулан гарч байгаа эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих зээлд 3 бизнес эрхлэгч хамрагдан 300.0 сая төгрөгийн зээлд хамрагдсан. . | | |
| | Арга хэмжээ-2: Бизнес эрхлэгчдийг гадаад, дотоодын төсөл хөтөлбөр, хөнгөлөлттэй зээл, батлан даалтын үйлчилгээ авахад дэмжлэг үзүүлэх | Бизнес эрхлэгчдийг гадаад, дотоодын төсөл хөтөлбөр, хөнгөлөлттэй зээл, батлан даалтын үйлчилгээнд хамрагдсан тоо, мөнгөн дүн | 388.0 сая төгрөгийн зээл, 532.5 сая төгрөгийн батлан даалтад хамруулсан. | 2021 онд: Төсөл хөтөлбөр, хөнгөлөлттэй зээл, батлан даалтын үйлчилгээнд хамруулна.<br>2022 онд: Төсөл хөтөлбөр, хөнгөлөлттэй зээл, батлан даалтын үйлчилгээнд хамруулна. | Эх үүсвэр: Улсын болон орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр Нийт: -<br>2021 онд: -<br>2022 онд: -<br>2023 онд: -<br>2024 онд: - | Орхон аймгийн хэмжээнд төрийн байгууллагаас "Эрүүл мэндээ хамгаалж эдийн засгаа сэргээх цогц төлөвлөгөө"-нд тусгагдсан хөнгөлөлттэй зээлд 1212 төсөлд 89 тэрбум төгрөгийн санхүүжилт, бусад хөнгөлөлттэй зээлд 84 нь төсөлд 932 сая төгрөгийн зээл олгосон байна. Дээрх хөнгөлөлттэй зээлд хамрагдсан 7 ААН нийт 870,3 сая төгрөгийн зээлийн батлан даалтад хамрагдсан байна. | 100 | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 2023 онд Төсөл хөтөлбөр, хөнгөлөлттэй зээл, батлан даалтын үйлчилгээнд хамруулна.<br><br>2024 онд: Төсөл хөтөлбөр, хөнгөлөлттэй зээл, батлан даалтын үйлчилгээнд хамруулна. | | "Хөгжлийн шийдэл" ТТБ-ын "BEST" Хөтөлбөрөөс зохион байгуулсан 10 сая төгрөг хүртэлх буцалтгүй бичил санхүүжилтийн тэтгэлэгт орон нутгийн 4 байгууллага хамрагдаж 40 сая төгрөгийн дэмжлэг авсан. 2023 онд Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн зээлд хамрагдахаар 1_7 тэрбум төгрөгийн санхүүжилт хүссэн 11 төсөл цахим системд ирүүлснийг хүлээн авч журмын дагуу судлан аймгийн дэд хороогоор хэлэлцүүлэн 70-с дээш оноо авсан 5 төсөлд 894.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон. Сумдын хоршоо хөгжүүлэх сангаас 27 иргэн, аж ахуйн нэгжид 533.0 сая төгрөгийн зээл олгосон. Монгол улсын Засгийн газраас хэрэгжүүлсэн хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөрийн хүрээн 22 аж ахуйн нэгж, 18 иргэнд 14.2 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | олгогдоод байна. Арилжааны банкаар дамжуулан гарч байгаа эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих зээлд 3 бизнес эрхлэгч хамрагдан 300.0 | | |
| Зорилт-3. Ахуйн үйлчилгээний салбарыг хөгжүүлнэ. /ЗДҮАХ-ийн 7.2.2./ | Арга хэмжээ-1: Ахуйн үйлчилгээ хөтөлбөрийг хэрэгжүүлэх | 1.Мэдээллийн сангийн баяжилт /нэр төрөл/ 2.Явуулын ахуйн үйлчилгээ зохион байгуулсан байна. 3.Чадавхижуулах сургалтад хамрагдсан иргэн, аж ахуйн нэгжийн тоо | Ахуйн үйлчилгээний салбарын мэдээллийн сан бий болгож, 23 нэр төрлийн үйлчилгээ хамрагдсан. | 2021 онд: Хөтөлбөрийг батлуулж хэрэгжүүлнэ.<br>2022 онд: Хөтөлбөрийн хэрэгжилтийг 40%-д хүргэнэ.<br>2023 онд: Хөтөлбөрийн хэрэгжилтийг 60%-д хүргэнэ.<br>2024 онд: Хөтөлбөрийн хэрэгжилтийг 100%-д хүргэнэ. | Эх үүсвэр: Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр Нийт: 100.0 сая.төг 2021 онд: 10.0 2022 онд: 30.0 2023 онд: 30.0 2024 онд: 30.0 | 2021 онд: "Ахуйн үйлчилгээг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг Хэрэгжүүлэх аймгийн 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 4 зорилтын хүрээнд 13 арга хэмжээг тусган аймгийн Засаг даргын батлуулан хэрэгжүүлэлтийг 100 хувь хангаж ажилласан. - Ахуйн үйлчилгээний эрхлэгчдийн судалгааг шинэчилсэн. Аймгийн хэмжээнд 294 иргэн 24 ААН үйл ажиллагааг явуулж байна. Аймгийн Үйлдвэрлэл хоршооллын холбоо Жаргалант сумын ЗДТГ-тай хамтран. " Явуулын ахуйн үйлчилгээ"-г зохион байгуулж, сумын малчид, тариаланчид 8 төрлийн үйлчилгээнд давхардсан тоогоор 130 иргэн хамрагдаж 1,5 сая төгрөгийн | 100 | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бүтээгдэхүүний борлуулалт хийгдсэн. Үйлчилгээний соёл, ёс зүй, ур чадвар, "Үйлчилгээний соёлыг эрхэмлэе" 4 удаагийн сургалтыг зохион байгуулж 103 иргэнийг хамруулсан. Оёмол бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн үйлдвэрлэсэн ажлын тусгай хувцас хамгаалах хэрэгслийн 5 үйлдвэрлэл эрхлэгчийн 20 гаруй нэр төрлийн 60 хувцас хамгаалах хэрэгслийн нэгдсэн каталог гаргаж төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрууд, хувийн хэвшлийн томоохон ААН-үүдэд сурталчилсан. Аймгийн ахуйн үйлчилгээ эрхлэгч ААН иргэдийн дунд аймгийн шилдэг ахуйн үйлчилгээ эрхэлж шалгаруулах уралдаан зарлаж "Charming relax center" , Тогос салон кристал хими цэвэрлэгээ шилдэг ахуйн үйлчилгээ эрхлэгчээр шалгарсан. Тайланд онд улс, орон нутгийн төсвөөс 10 сая | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төгрөг зарцуулсан. 2022 онд: - Ахуйн үйлчилгээний салбарын цахим мэдээллийн сантай болох зорилгоор аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй ахуйн үйлчилгээний салбарын 74 бизнес эрхлэгчдийн цахим судалгаанд хамруулсан. -Тайланд хугацаанд 6 сургалтад давхардсан тоогоор 412 иргэн хамрагдсан. Аймгийн Засаг даргын 2023 оны А/511 дүгээр захирамжаар “Ахуйн үйлчилгээний салбарыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг орон нутагт хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг баталсан. Төлөвлөгөөнд 4 зорилт 10 арга хэмжээг 100 хувь хэрэгжүүлэн ажилласан. Аймгийн хэмжээнд ахуйн үйлчилгээний салбарт 346 цэгт аж ахуйн нэгж, иргэн үйл ажиллагаа явуулж байгаагийн 14 буюу 4.0 хувь нь нийтийн халуун ус, 80 буюу 23.1 хувь нь үсчин, гоо сайхан 85 буюу 24.6 хувь нь | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хувцас захиалга, засвар, 4 буюу 1.4 хувь нь гэрэл зураг авах, угаах, 3 буюу 0.9 хувь нь хими цэвэрлэгээ, угаалга, 3 буюу 0.9 хувь нь ахуйн электрон, цахилгаан хэрэгсэл засвар, 24 буюу 6.9 хувь нь гутал захиалга, засвар, 19 буюу 5.5 хувь нь гэр ахуйн модон эдлэл захиалга, засвар, 8 буюу 2.3 хувь нь алт, мөнгө, үнэт эдлэлийн захиалга, засвар, 106 буюу 30.6 хувь нь бусад үйлчилгээний чиглэлээр тус тус үйл ажиллагаа явуулж байна. | | |
| | Арга хэмжээ-2: Ахуйн үйлчилгээний чанар, стандартын хэрэгжилтийн түвшинг дээшлүүлэх эд сургалт, сурталчилгааны ажлуудыг зохион байгуулж, тохирлын | Тохирлын үнэлгээнд хамрагдсан иргэн, аж ахуйн нэгжийн тоо | Шаардлага хангасан үйлчилгээний хувь 20% | 2021 онд: 5 үйлчилгээ<br>2022 онд: 10 үйлчилгээ<br>2023 онд: 10 үйлчилгээ<br>2024 онд: 20 үйлчилгээ | Эх үүсвэр: Орон нутгийн төсөв Нийт: 6.0 сая.төг<br>2021 онд: -<br>2022 онд: 2.0<br>2023 онд: 2.0<br>2024 онд: 2.0 | 2021 онд: Үсчин гоо сайхны үйлчилгээний шинээр мөрдөгдөж эхэлсэн "Үс засах үйлчилгээ" MNS 5160:2020, "Хумс засал үйлчилгээ" MNS 6843:2020 стандартын сургалт зохион байгуулах ажлыг Стандарт хэмжүүл зүйн хэлтэс, Хөгжлийн шийдэл ТББ-аас хэрэгжүүлж буй BEST хөтөлбөр, мэргэжлийн холбоотой хамтран | 100 | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | үнэлгээнд хамруулах | | | | | зохион байгуулсан. Энэ онд ахуйн үйлчилгээний чиглэлээр 3 ААН тохирлын үнэлгээг хийж баталгаажуулалтад хамруулан үнэлгээний үзүүлэлтийг үндэслэн 1-2 жилийн хугацаатай тохирлын гэрчилгээ олгогдсон. 2022 онд: 8 багийн 71 цэг салб Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ийн Спорт цогцолбор, “Бат түшигт хан” ХХК-ны халуун ус, сауны үйл ажиллагааг хянан халуун усны үйлчилгээ MNS 5163:2002, сауны үйлчилгээ MNS 5164:2010 стандартын шаардлагыг хангасан тул халуун ус 2 жил, саун 1 жилийн хугацаатай, үсчин, гоо сайхан, хумс заслын “Чамин” салон ”Үс засах үйлчилгээ” MNS 5160:2020, “Хумс заслын үйлчилгээ” MNS 6843:2020 стандартын шаардлагыг хангаж 2 жилийн хугацаатай тохирлын гэрчилгээг олгосон.арын үйл ажиллагаатай танилцахад стандартын шаардлагатай хангасан | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | "Сэрвэн цахир" , "Үзэм гоо" , "Жавхлан" , "Сувд гоо" , "Болор" зэрэг нийт 5 үсчний газар тохирлын гэрчилгээ олгоод байна. | | |
| | Арга хэмжээ-3: "Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр-III"-ийг хэрэгжүүлэх | 1.Чадавхижуулах сургалтад хамрагдсан хоршоодын тоо<br>2.Загвар хоршоо байгуулагдсан байна. | Улсын бүртгэлтэй 70 хоршоо, идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй 23 хоршоо байна. | 2021 онд: Чадавхижуулах сургалтад 15 хоршоог хамруулна.<br>2022 онд: Чадавхижуулах сургалтад 15 хоршоог хамруулна.<br>2023 онд: Чадавхижуулах сургалтад 15 хоршоог хамруулна.<br>2024 онд: Загвар хоршоо байгуулагдсан байна. | Эх үүсвэр: Орон нутгийн төсөв<br>Нийт: -<br>2021 онд: -<br>2022 онд: -<br>2023 онд: -<br>2024 онд: - | 2021 онд: Хоршоодын гишүүд болон хоршоо шинээр үүсгэн байгуулагчтай иргэдэд "Хоршооны тухай ойлголт" , "Татварын ерөнхий хууль" , "ХАА-н гаралтай бараа түүхий эд биржийн тухай хууль" , "Хоршооны сайн засаглал ба анхаарах асуудал" , "Төрийн худалдан авалтад бүтээгдэхүүн нийлүүлэх" зэрэг чадавхжуулах 5 сургалтыг ХХААГ Баян-Өндөр сум АНУ-ын Олон улсын санхүүжилттэй хөгжлийн шийдэл ТББ-ыг Best хөтөлбөр, "Хоршооллын сургалт мэдээллийн төв ТББ-тай хамтран зохион байгуулж нийт давхардсан тоогоор 10 хоршооны 60 төрлийг хамруулсан. 2022 онд: Монгол Улсын ЗГ-аас 2022 оныг "Хоршооны хөгжлийг дэмжих жил" болгон зарласантай | 100 | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | холбогдуулан "Хоршооны хөгжлийг дэмжих жил 2022" Нээлтийн арга хэмжээ, "Хоршоологчдын зөвлөгөөн" зохион байгуулж давхардсан тоогоор хоршоодын 150 төлөөлөл оролцож холбогдох мэдээлэл авсан. ХАА-н бирж ХХК Хоршооллын сургалт мэдээллийн төв, ХАА-н хоршоологчдын холбоотой хамтран 4 удаагийн цуврал сургалт зохион байгуулж давхардсан тоогоор нийт 310 иргэн хоршоодын төлөөлөл хамрагдаж жилийн эцсийн санхүүгийн та Аймгийн Засаг даргын 2023 оны А/241 дүгээр захирамжаар 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөө батлагдсан. 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд хоршоог хөгжүүлэх чиглэлээр 6 арга хэмжээ зохион байгуулахаар төлөвлөн хэрэгжилтийг 100 хувь ханган ажилласан.йлан гаргах ХАА-н биржийн | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | мэдээлэл хоршооны засаглалын талаар мэдлэгтэй болсон. | | |
| **Долоо.Ерөнхий чиг үүргийн нэр: Санхүү, хөрөнгө оруулалтын чиглэлээр** | | | | | | | | |
| **7.1.Үндсэн чиг үүргийн нэр:** Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын эдийн засаг, хөрөнгө оруулалтыг төлөвлөх, төсөв боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах, санхүүгийн байдлыг тайлагнах, төрийн сангийн үйл ажиллагааг эрхлэх үндсэн үүрэг хүлээж, энэ хүрээнд хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын эдийн засгийн үр ашгийн шинжилгээ хийх, төсвийн шууд захирагчийн төсвийн төсөл, хөрөнгө оруулалт, зардлын жилийн болон дунд хугацааны төсвийг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр төлөвлөх, бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, батлагдсан төсвийг захиран зарцуулах, тайлагнах, зохицуулалтыг хангах, мэдээллийн сан бүрдүүлэх, төсвийг ил тод мэдээлэх, гадаадын төсөл, хөтөлбөрийн төсвийн нэгдсэн төлөвлөлт, зохицуулалтыг хангах, санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, газрын санхүү, аж ахуйн үйл ажиллагааг тасралтгүй явуулах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд хариуцах чиг үүргийг хэрэгжүүлнэ. | | | | | | | | |
| Зорилт-1. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, үндэсний үйлдвэрт бүтээгдэхүүнээ нийлүүлсэн малчид, тариаланчдад төрөөс урамшуулал олгоно. /ЗГҮАХХАХТ-ийн 3.3.11/ | Арга хэмжээ-1: Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд төрөөс олгох татаас, мөнгөн урамшууллын хэрэгжилтийг хангаж ажиллах | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | Улаанбуудай тариалдаг 6 ААН, 1 иргэний гурил үйлдвэрлэлд нийлүүлсэн 6127 тн улаан буудайд мөнгөн урамшуулал олгосон. Арьс, ширний урамшуулалд 219 өрхийн 5310 ширхэг арьс ширэнд 29.1 сая төгрөг. Ноосны урамшуулалд 49 өрхийн 6970 кг ноосонд 10.4 сая төгрөг | 2021 онд: Үйлдвэрт нийлүүлсэн хүнсний улаанбуудай, ноос, ноолуур, арьс шир, сүү урамшуулал олгоно.<br>2022 онд: Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд төрөөс олгох дэмжлэг, мөнгөн урамшуулалд иргэн, аж ахуй нэгжийг хамруулна. | Эх үүсвэр: Улсын төсөв Нийт: - 2021 онд: - 2022 онд: - 2023 онд: - 2024 онд: - | 2021 онд: ЗГ-ын 2019 оны 343 дугаар тогтоолоор баталсан "Хонь тэмээний ноос бэлтгэж үндэсний үйлдвэрт тушаасан малчин мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох журмын шаардлага хангасан Орхон аймгийн Баян-Өндөр Жаргалант сумын 48 малчин мал бүхий этгээд 7,1 тн хонины ноосыг " Эрдэнэт текс" ХХК-д нийлүүлж 10.6 сая төгрөгийн урамшуулалд хамрагдсан байна. Баян-Өндөр сум 23000 толгой ямаанаас 7200кг ноолуур, Жаргалант 29000 толгой ямаанаас | 100 | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Ноолуурын урамшуулалд 540 өрхийн 13.5 мянган кг ноолууранд 270.0 сая төгрөгийн урамшуулал олгосон. | 2023 онд: Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд төрөөс олгох дэмжлэг, мөнгөн урамшууллалд иргэн, аж ахуй нэгжийг хамруулна.<br><br>2024 онд: Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд төрөөс олгох дэмжлэг, мөнгөн урамшууллалд иргэн, аж ахуй нэгжийг хамруулна. | | 9100 кг буюу нийт 16300 кг ноолуур бэлтгэсэн. 2022 онд: ЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт "Сүүний чиглэлийн үхрийн эрчимжсэн аж ахуйн үйлдвэрийг нэмэгдүүлж, дотоодын сүү үйлдвэрлэл, боловсруулалтыг өсгөж, "Сүү боловсруулах үйлдвэр цехэд техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн түүхий сүү нийлүүлсэн малчин эрчимжсэн МАА эрхлэгчдэд мөнгөн урамшуулал олгох журмыг ЗГ-ын 2020 оны 130 дугаар тогтоолоор баталсан. Дээрх тогтоолын хүрээнд малчин эрчимжсэн МАА-н эрхлэгч нь үйлдвэр цехэд малын түүхий сүү нийлүүлэхэд цахим бүртгэлийн талаарх сургалтын 2022 оны 11 дүгээр сард МЭГ, Татварын хэлтэстэй хамтран зохион байгуулсан.Үүнд: 11 фермер эрхлэгч , 5 мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүд хамрагдсан. | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2023 онд Тариалангийн үйлдвэрлэлийн нэгдсэн систем plant.mofa.gov.mn цахим системд аймгийн хэмжээнд 468 нэгж талбарын 5239 га тариалангийн талбай, 308 иргэн, 28 аж ахуйн нэгж бүртгүүлсэн Тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч 563 иргэн, 12 аж ахуйн нэгжийн тариалалтын мэдээг таримал тус бүрээр нь аймгийн статистик тулган баталгаажуулахажил хийгдсэн. 2022 оны ургацын цахимаарилгээгдсэн 175 удаагийн урамшууллын хүсэлтэд 900.0 сая төгрөгийн урамшууллыг 7 аж ахуйн нэгж, 135 иргэн авсан. “Сүү боловсруулах үйлдвэр, цехэд техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн малын түүхий сүү нийлүүлсэн малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид мөнгөн урамшуулал олгох журам” -аар 2023-2024 оны сүү хүлээн авах | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үйлдвэр, цехийн сонгон шалгаруулалтад Баяжуулагч одод ХХК, Эрдэнэт хаан сүү ХХК-ууд тэнцэж, Баяжуулагч одод ХХК Орхон, Булган, Дархан, Сэлэнгийн 34, Эрдэнэт хаан сүү ХХК Орхон, Сэлэнгийн 10 малчин, фермертэй гэрээ байгуулсан. Баяжуулагч одод ХХК-ийн сүүний үйлдвэрт 2022 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд 50 малчин, фермер 47451 литр сүү нийлүүлж, 23.7 сая төгрөгийн урамшуулал олгогдсон. | | |
| Хэрэгжилтийн хувь 97.97 хувь | | | | | | | | |

ОРХОН АЙМАГ ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР